



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-52

1.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	5-37
2.Үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүнд хийсэн аудитын тайлан	37-46
3.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан	46-52

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 23-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 52 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан, Б.Түвшин;
Чөлөөтэй: Д.Батбаяр, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн,
Д.Энхтүвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар,
Б.Мөнхсоёл.

**Нэг.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай
хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн
2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Р.Батболд, Ч.Номин, П.Сайнзориг, Да.Цогтбаатар, Д.Үүрийнтуяа, Б.Заяабал, Н.Алтанхуяг, Л.Мөнхбаясгалан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны хуралдааныг 14 цаг 34 минутаас 15 цаг 24 минутад түр завсарлуулав.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Н.Наранбаатар: Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүнд хийсэн аудитын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Б.Саруул, И.Туяадарь, ахлах аудитор Б.Батдэлгэр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүнд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Заяабал нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны гишүүд Үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүнд хийсэн аудитын тайланг хэлэлцлээ.

Уг асуудлыг 16 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын ахлах аудитор О.Баярмаа, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын аудитын менежер Н.Анхбаяр, мөн газрын аудитор П.Норпил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Заяабал нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын аудитын менежер Н.Анхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны гишүүд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайланг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 46 минут үргэлжилж, 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их засаг” танхим 12 цаг 52 минут

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Н.Наранбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье ээ.

Төсвийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 51.7 хувьтай бүрдсэн тул 2025 оны 12 сарын 23-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны ирц бүрдсэн тул ирцэд орсон гишүүд танхимд хүрэлцэн ирнэ үү. Ирцийг танилцуулъя. 7 дугаар тойрог Нанзадын Наранбаатар ирсэн, 12 дугаар тойрог Жуковын Алдаржавхлан ирсэн, 3 дугаар тойрог Тилеуханы Аубакир ирсэн, жагсаалт Ринчендоржийн Батболд ирсэн, 5 дугаар тойрог Жигжидийн Батжаргал ирсэн, жагсаалт Жамбын Батсуурь ирсэн, 4 дүгээр тойрог Цэрэнпилийн Даваасүрэн ирсэн, 11 дүгээр тойрог Пүрэвжавын Сайнзориг ирсэн, 2 дугаар тойрог Батжаргалын Заяабал ирсэн, 2 дугаар тойрог Загджавын Мэндсайхан ирсэн, 11 дүгээр тойрог Чинбатын Номин ирсэн, жагсаалт Даваахүүгийн Пүрэвдаваа ирсэн, 4 дүгээр тойрог Доржсүрэнгийн Үүрийнтуяа ирсэн, 1 дүгээр тойрог Даваагийн Цогтбаатар ирсэн, 2 дугаар тойрог Баттогтохын Чойжилсүрэн ирсэн.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийн хэлэлцэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай нарын 21 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна.

2.Үр дүнд суурилсан төлөвлөлтийн шилжилтийн үйл явц үр дүнд хийсэн аудитын тайлан хэлэлцэнэ.

3.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүнд хийсэн аудитын тайланг хэлэлцэх.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа орёе оо.

Нэг дэх асуудал. Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийг оруулаарай.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД орж ирээгүй байна уу? Дуудаарай. Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн

бодлого төлөвлөлтийн газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Огнонгийн Хуягцогт Эрчим хүчний яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Түмэндалайн Даваадалай НЗД-ын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны өрийн удирдлагын хэлтсийн дарга. Алга байна дуудаарай. Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Маамын Үнэнбат НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Лхагвадоржийн Эрдэнэбадрах НЗДТГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Дашдаваагийн Алтанцэцэг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал.

Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай танилцуулна аа. Алтаншагай гишүүний микрофоныг өгөөрэй.

Н.Алтаншагай: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе ээ. Танилцуулга хийе ээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын нийт 21 гишүүнээс санаачлан Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Монгол Улс 1990 оноос хойш ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудад гишүүнээр элсэж, зах зээлийн эдийн засгийн шилжилтийг давах эдийн засгийн болон нийгмийн дэд бүтцийг бий болгох зэрэг дээрх олон улсын байгууллага 2 талт хамтын ажиллагааны хүрээнд Засгийн газраас гадаадын нэн хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийг авч ашиглаж ирсэн. 2011 оноос нэн хөнгөлөлттэй нөхцөл өөрчлөгдөж энгийн болон хөнгөлөлттэй зээлд хамрагдах болсон. Харин 2024 оноос эхлэн манай улс дунджаас дээгүүр орлоготой улс болсон тул зөвхөн арилжааны нөхцөлтэй зээл авах боломжтой болж зээлийн нөхцөл өөрчлөгдөж байна аа. Өнгөрсөн хугацаанд нийт 21.7 их наяд төгрөгийн гадаад зээллэгийг авч ашиглан дэд бүтэц, худалдаа, эдийн засаг, эрчим хүч, эрүүл мэнд, боловсрол, уул уурхай ХАА нийгмийн хамгааллын чиглэлээр 300 гаруй төслийг хэрэгжүүлсэн байна аа.

Үүнд:

Япон улсын зээлээр шинэ олон улсын нисэх онгоцны буудал барих төсөл, Тусламжийн хөрөнгөөр Япон, Монгол, Монголын анагаах ухааны эмнэлэг, БНХАУ-ын зээлээр Төв цэвэрлэх байгууламж барих төсөл, Улаанбаатар Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын хурдны авто зам барих төсөл, Яармагийн болон замын цагдаагийн гүүр барих төслүүд, Гачуурт, Налайхын авто замын төсөл, АХБ-ны зээлээр Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Дэлхийн банкны зээлээр эрчим хүчний алдагдал бууруулах эрчим хүчний шинэчлэл хийсэн эрчим хүч 1, 2 төсөл зэрэг томоохон төслүүдийг ашиглалтад оруулсан байна аа.

Харин өнөөдрийн байдлаар Улсын Их Хурлаас соёрхон баталсны дагуу Засгийн газрын шугамаар гэрээ хэлэлцээр нь байгуулагдаад, гадаад зээл, тусламжийн нийт 116 төсөл хэрэгжиж байгаагаас гадаад зээлийн 89 төсөл байна аа.

Эдгээр төслийн зээлийн санхүүжилтийн ашиглаагүй нийт үлдэгдэл 14.7 их наяд төгрөг, түүнчлэн 95,5 хувь нь 2030 он гэхэд дуусахаар гэрээ хэлэлцээр байгуулсан байна аа. Гэвч зээлийн ашиглалтын хэмжээ тухайн жилийн төсөвт хязгаарлагдмал байдлаар батлагдаж байгаагаас шалтгаалж эдгээр төслүүдийн хэрэгжилт удаашрах, нэмэлт санхүүжилт үүсэх, зээл зээлийн үйлчилгээний төлбөр нэмэгдэх, зарим төслүүд 10 хүртэл жил удаашрах эрсдэлтэй байна аа.

Иймд гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдээс Үндэсний аюулгүй байдлыг хангах Улсын Их Хурлаас баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 14 мега төслийн жагсаалтад багтсан импортыг орлож үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх чадамжтай нийгэм эдийн засгийн өндөр ач холбогдол үр ашиг бүхий газрын тос боловсруулах үйлдвэр Эрдэнэбүрэнгийн УЦС барих төсөл болон Сэлбэ дэд төвийг түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийг хугацаанд нь санхүүжүүлэх ашиглалтад оруулах зорилго бүхий анхдагч хуулийн төслийг зарим гишүүдийн хамт боловсруулан өргөн бариад байна аа.

Өмнө дурдсан зээлийн ашиглагдаагүй үлдэгдлийн 38 хувь буюу 5.6 их наяд төгрөг нь газрын тос боловсруулах үйлдвэр Эрдэнэбүрэнгийн УЦС барих төслүүдийн санхүүжилт байна аа. Гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй зөвхөн дээрх 3 төслийн санхүүжилтийн ашиглалтын зардлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1.4, 12.1.5-д заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээ болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн тооцооллоос бусад нь тооцож авах тухай зохицуулалт юм аа.

Хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл бөгөөд дээрх төслүүдийн Улсын Их Хурлаас соёрхон баталсан хугацаагаар хэрэгжих зээлийн ашиглалт нь гэрээ хэлэлцээр батлагдсан дүнгээс хэтрэхгүй байх хязгаарлалттай бөгөөд бүтцийн хувьд 9 зүйлтэй. Хуулийн төсөлд хамаарах төслүүдийг тодорхой тусгасан болно оо.

Харин дээрх төслүүдийн ашиглалтын хэмжээгээр Засгийн газрын өрд бүртгэх, өрийн хязгаарт тооцох зэрэг бусад харилцаанд хуулийн төсөлд өөрчлөлт оруулахгүй бөгөөд хуулийн төсөлд тусгаснаас бусад асуудлыг холбогдох хуулийн хуулиар зохицуулна.

Анхдагч хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангаж холбогдох судалгааг боловсруулж өргөн барьсан. Тухайлбал судалгаанаас үзэхэд олон улсад ийм туршлагатай түгээмэл байдаг бөгөөд ХБНГУ, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй улсууд хөгжлийн томоохон төслүүдийн иймэрхүү байдлаар санхүүжүүлж ирсэн, туршлагатай байна аа.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хууль батлагдсанаар дараах эерэг үр дүн нөлөө үр ашиг гарна аа.

Үүнд:

Газрын тос боловсруулах үйлдвэр хугацаандаа баригдсанаар жилд 1.5 сая тонн түүхий газрын тос боловсруулна. Жилдээ 1.3 сая тонн евро 4, евро 5 бензин, дизель түлш онгоцны түлш, шингэрүүлсэн шатдаг хий зэргийг үйлдвэрлэнэ ээ. Мөн газрын тосны бүтээгдэхүүний дотоодын хэрэглээний 55 хувийг дангаараа хангах,

шинээр 700 гаруй ажлын байр бий болно. Жил бүр 1 тэрбум ам.доллар дотооддоо үлдэж, импортын хараат байдлаас гарч шатахууны үнийг бие даан уян хатнаар шийдвэрлэх зохицуулалттай болно оо.

Эрдэнэбүрэнгийн УЦС ашиглалтад орсноор жилдээ 336 сая квт цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ. Баруун бүсийг 100 хувь баруун бүсийн 5 аймгийг цахилгаан эрчим хүчээр хангана. Жил бүр 17.5 тэрбум төгрөгийн дотооддоо үлдээж, импортын цахилгаан эрчим хүчийг орлоно оо. Бүтээн байгуулалтын ид үед болон ашиглалтад ороход нийт 866 ажлын байр шинээр бий болохоор байна. Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулснаар Улаанбаатар хотод гэр хорооллын бүсэд 158 га талбайг орон сууцжуулж 10 мянга орчим айлын орон сууцаар хорооллыг бий болгож Улаанбаатар хотын гэр хорооллын 18 мянга орчим янданг цөөрүүлж, Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдлыг бодит хувиар бууруулах. 14 мянга орчим нүхэн жорлонг устгаж хөрсний болон орчны бохирдлыг бууруулна. 800 гаруй ажлын байр шинээр бий болох, мөн зээлийн ашиглалтыг сайжруулснаар газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслийн зээлийн ашиглагдаагүй үлдэгдэлд төлөх төлбөрт 26.7 сая ам.доллар буюу 96.1 сая тэрбум төгрөгийг хэмнэх бөгөөд хэмнэсэн мөнгөөр нийт 6-аас 7 мянга орчим суудалтай таваа 5-аас 7 сургуулийг ийм барих ийм эдийн засгийн тооцоолол хийгдсэн байна.

Энэхүү хууль батлагдсанаар нийт гарах үр дүн дээрхээр хязгаарлагдахгүй бөгөөд стратегийн гол бүтээгдэхүүний импортын хэт хамаарал буурч валютын гадагшлах урсгал эрс багасаж Улсын Их Хурлаас соёрхон баталсан зээлийн гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж олон улсын хөгжлийн түнш байгууллагуудтай байгуулсан гэрээний үүргээ биелүүлнэ ээ.

Төсөвт учруулах гадаад зээлийн дарамтыг багасгах, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, бусад шинэ зээлийн төслүүд хугацаандаа хэрэгжиж зээлжих зэрэглэл нэмэгдэх боломж бий болох юм аа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Үндэсний аюулгүй байдлын гол бүтээгдэхүүн болох газрын тосны бүтээгдэхүүний дотооддоо үйлдвэрлэх үнийг дотооддоо тогтоох боломж олгох, Баруун бүсийг 100 хувь дотоодын эрчим хүчээр хангах импортын хараат байдлаас гарах гэр хорооллыг орон сууцжуулах, Улаанбаатар хотод тулгамдаад буй агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэх 3 төслийг хугацаанд нь ашиглалтад оруулах хууль эрх зүй орчныг бий болгох энэхүү хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Алтаншагай гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны гишүүдээс ирцэд нэмж ирсэн, гишүүдийг танилцуулъя.

11 дүгээр тойрог Норовын Алтанхуяг ирсэн байна. 7 дугаар тойрог Гомбын Ганбаатар, жагсаалт Пүрэвийн Ганзориг гишүүд нэмэгдэж ирсэн байна. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ганбаатар гишүүнээр тасаллаа. Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өдрийн амар амгаланг айлтгая. Гадаадын зээл ашиглалтын нэмэгдүүлэх талаар энэ анхдагч хуулийн төсөл боловсруулж өргөн мэдүүлсэн байна. Үнэхээрийн бид энэ гэрээ хэлцлийг нь хийчихсэн гадаадын зээлийн хөрөнгийнхөө ашиглалтыг сайжруулахгүй бол болохгүй байгаад байгаа юм. Цаана нь байж байгаа том бүтээн байгуулалтын ажлууд удаашрах гээд байгаа. Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, төсвийн тусгай шаардлагатайгаа уялдаад асуудлыг хүндрүүлээд байгаа юм аа.

Тийм учраас энүүнийг бид зөв зохицуулах зайлшгүй шаардлага байгаа гэж ингэж ойлгож байна. Яг одоогийн байдлаар гадаад зээлийн тусгай шаардлагынхаа хүрээнд түвшин нь хэдэн хувьтай байгаад байгаа вэ гэдэг асуудал. Энэ 3-ын зээлийн ашиглалтыг хурдасгахаар ер нь 2026 онд хэдэд хүрэхээр тооцогдсон бэ гэдэг асуудал нэг байгаад байгаа юм.

Хоёр дахь зүйл. Энэ Сэлбэ дэд төвийн орон сууцжуулалтын асуудлын хөрөнгийг би босгочихсон гэж ойлгоод байгаа. Энэ ер нь хэдий хэмжээний хөрөнгө буцаагаад зардал талд бичилт хийгээд гүйцэтгэл яваад эхлэхээр зэрэг хэдий хэмжээний хөрөнгө төсвийн зардал талд тусгагдах гээд байгаа вэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Энэ ямархуу байдалтай байна вэ? Нэг хэсэг энэ чинь яг энэ 3-аар нэг орж ирмээр болсноо сэлбийх бол ерөнхийдөө болчихлоо. Газрын тос боловсруулах Эрдэнэбүрэнгийн 2-ын асуудал л байна гэдэг юм яригдаад байсан юм. Сая дахиад ороод ирсний учир шалтгаан нь юу байгаад байгаа юм гэдэг асуудал. Энэ манай холбогдох яамдууд байгаад байна.

Ер нь бид ийм зохицуулалтаар цаашаа зээлийн хөрөнгийн ашиглалтыг авч явах юм уу, эс үгүй бол энэ Хөгжлийн банкаа түшиглэж Засгийн газар тэр баталгаагаа гаргах хэлбэрээрээ явах юм уу гэдэг асуудал байгаа юм аа. Энд эрх зүйн ямар зохицуулалт хийж байж энэ зөв болох юм бэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Ийм 3 асуултад хариу аваадахъя.

Н.Наранбаатар: Алтаншагай гишүүний микрофон. Сангийн яам хэддүгээр микрофон байна? Санжаадорж хариулъя Индрийн микрофон.

Л.Гантогтох: Гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох. Засгийн газрын өр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байхаар заасан хязгаартай. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар Засгийн газрын өр нийт 35.7 их наяд төгрөг. ДНБ-ий эзлэх хэмжээ 39.5 хувьтай тэнцэж байна. 2026 онд эдгээр зээлүүдийн ашиглалт гарч байгаа төсөөлөл бол Засгийн газрын өр 41.9 их наяд. ДНБ-ий хувьд харьцуулсан харьцаа нэг 40.9 хувь хавьцаа байхаар төсөөлөлтэй байна.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя аа. Ер нь гадаад зээлтэй холбоотойгоор бол манай улсад хэрэгжүүлж байгаа бол хамгийн том 3 төсөл бол энэ хуулийн төсөл дээр туссан байна лээ. Эрдэнэбүрэн болон газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд бол хэрэвзээ одоогийн төсвийн энэ хайрцагтаа бид нар багтаагаад аваад явна гэх юм бол магадгүй 20 жил түүнээс ч олон жил шаардах юм байна гэж бид тооцоод байгаа. Яагаад гэхлээр жил болгон 200 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт өгөөд явахад бол энэ төсөл дуусахгүй.

Нэгэнт Улсын Их Хурлаас шийдвэрээ гаргаад энэ төслийг бол хэрэгжүүлэх нь зөв зүйтэй байна гээд зээлээ авчихсан аль болох хурдан ашиглалтад оруулаад үүнийхээ үр шимийг хүртээд энэ нь эргээд эдийн засгаа тэтгээд эдийн засагтаа энэ бодит өгөөж болох энэ асуудлаар нь бол бид энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа.

Харин Сэлбэ дэд төвийн хувьд бол ямар асуудал үүсэж байна гэдгийг хэлэхээр бол Сэлбэ дэд төв маань бол өөрөө ноднин бол бондоо гаргасан байж байгаа. Тэгээд энэ бондыг бол бид нар 2024 онд зарцуулна гээд төсвийг нь тавьчихсан байсан. 2025 онд дахиад төсвийг нь зарцуулна гээд тавьчихсан. Гэтэл энэ маань дахиж юу гэдэг юм жаахан удаашралтай байгаагаас шалтгаалаад ирэх онд бол дахиад нэг 600, 700 орчим тэрбум төгрөгийн зардал гарах болов уу гэж тооцоод байгаа юм. Энэ маань бол дахиад ирэх жилийн төсвийн хүрээний мэдэгдэл дээр бол бас нөгөө хязгаарлалтад орох гээд байгаа учраас энэ агуулгаараа энэ төсөл орж ирсэн байна гэж харж байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Индрийн микрофон нэмж хариулт өгнө.

Ж.Дэлгэржаргал: Сангийн яам Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал нэмж мэдээлэл өгье. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд бол нийт бид нарын ашиглах ёстой зээлийн ашиглалт маань 6 их наяд байгаа. Одоогийн байдлаар 1.3-ыг ашигласан. Тэгэхээр зээлийн хэлэлцээр Улсын Их Хурлаар соёрхон баталсан хугацаа бол 2028 он гэхэд бид нар энэ төслийн хувьд 4.7 их наядыг ашиглаж дуусах ийм хэлэлцээрийн хугацаатай.

Тэгэхээр одоогийн байдлаар гадаад зээлийн хувьд бол дунджаар жилд яг төсвийн зардал дээр 1.5 их наяд л батлагдаж байгаа. Тэгэхээр энэ 116 төслийн хувьд бид нар 1.5 их наяд батлагдаж байгаа учраас газрын тосны яг гаргах ёстой санхүүжилтийнх нь маш бага хувиар гарч байгаа. Одоо газрын тосноос гаргах ёстой санхүүжилт бол жишээлбэл 2026 оны төсөв дээр 1.7 их наяд ирсэн бол бид нар 207 тэрбумыг л яг ашиглалтынхаа хэмжээнд тавьж байгаа. Тэгэхээр энэ байдлаар явах юм бол Улсын Их Хурлаар соёрхон баталсан хэлэлцээрийн хугацаанд буюу 2028 онд бид нар 1 дүгээрт ашиглалтад оруулах боломжгүй.

Хоёрдугаарт хэрвээ газрын тосыг энэ хугацаанд ашиглалтад нь оруулъя гэвэл ганцхан энэ төслийг л бид нар төсвийнхөө ашиглалт талдаа тавих ийм тооцоолол байгаа. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын хувьд бол яг хугацаандаа явж байгаад өнгөрсөн жил эхэлсэн. Нийтдээ 908 тэрбумын бид нар 272-ыг бол гэрээ байгуулаад урьдчилгаа 10 хувь өгчихсөн байгаа. Үлдэгдэл 635 тэрбум байгаа. Хэлэлцээрийн хугацаа 2035 он байгаа. Тэгэхээр энэ 2 төслийн хувьд бол бусад төслүүдээс 7 шалгуур үзүүлэлтээр энэ хуулийн төсөлд гишүүний танилцуулснаар бүх шалгуур үзүүлэлтийг Сангийн яамны хувьд хангаж байна гэж үзээд дэмжиж байгаа.

Н.Наранбаатар: Нийслэлээс хариулт өгнө өө. 6 номерын микрофон.

Т.Даваадалай: Гишүүний асуултад хариулъя. НЗД-ын 1 дүгээр орлогч Даваадалай. 2024 оны 201 дүгээр тогтоолоор Сэлбийн бүтээн байгуулалтад 500 сая ам.долларын бонд босгох эрхийг авсан. Үүнийгээ 1.6 их наядын бондыг 2024 оны 10 дугаар сараас эхлээд 12 дугаар сард босгож авч дотоодын системийн банкнуудад байршуулж энэ жил гүйцэтгэл дээр 302 тэрбум төгрөг гарсан. 2026 онд бол төслийн гүйцэтгэлтэй уялдуулаад 850 тэрбумаар санхүүжилт хийгдэхээр байна.

Төслийн эхний 4 багцын бонд ашиглагдаж байгаа багцуудаас 117 блокийн 101 блокийг нь барилга угсралт талбай дээр эхэлчихсэн нийт 15 хувийн гүйцэтгэлтэй ажил хийгээд үргэлжилж байна. Одоогийн байдлаар талбай дээр 400-аад хүн, 50-иад техник ажиллаж байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Тодруулах уу? Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тиймээ энийг нь ч бол мэдээд л байгаа. Ер нь яг ийм анхдагч хуулиар цаашид гадаадын зээлийн ашиглалтыг хийгээд явах юм уу хэдүүлээ? Энэ Хөгжлийн банк гэж нэг банк байгуулчхаад энэнийхээ зорилго юмыг ер нь нэг их олигтой хэрэгжүүлж чадахгүй байгаад байгаа улс шүү дээ. Энүүгээрээ дамжуулж энэ өөрөө өөрийнхөө үйл ажиллагаагаар анхдагч хөрөнгөө нөхөөд үр ашигтай ажиллах том төслүүдээ энүүгээрээ санхүүжүүлж явуулах юм уу? Зүгээр гагцхүү Засгийн газар бол өрийн баталгаа гаргах хэлбэрээрээ явах нь зүйтэй юм биш үү л гэдэг санаа л надад байгаад байгаа юм л даа. Тэгэх юм бол энэ төсвийн харилцаа талаасаа ч тэр нэлээн тийм зөв голдирол руугаа л орох ёстой. Энүүн дээр манай энэ асуудлаа хариуцаад байгаа яамдууд ер нь ямар бодлого чиглэлтэй байгаад байгаа юм бэ? Үнэхээрийн бид зээлийг ашиглахгүй.

Н.Наранбаатар: Индрийн микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Батжаргал гишүүний асуултад хариулъя. Тийм, энэ асуудлыг бол нэг удаагийн шинжтэй хуулиар бол ингээд шийдээд яваад байж бол бид нар дараа дараагийн төслүүдээ том төслүүд хэрэгжинэ. Энэ бүгдийгээ алсаа харж явах нь бол зүйтэй. Энэний шийдлийг бол бид нар юу гэж харж байгаа вэ гэхлээр Хөгжлийн банкны хувьд бол өмнө нь нөгөө 2016 онд бид нар 2017 онд нөгөө валютын сангийн хөтөлбөрт ороход гол асуудал нь яасан гэхээр олон төсөвтэй болчихсон гэдэг ийм нэг шүүмжлэл яваад Хөгжлийн банкаар бол Засгийн газрын шинжтэй ийм төслүүдийг хэрэгжүүлэхгүй байна гэдэг ийм зүйл болчихсон юм. Гэхдээ энэ төслүүдийн хувьд бол Хөгжлийн банкуудаар дамжаад явахад ашигтай төслүүд учраас нийгмийн шинжтэй биш учраас бас байх боломжтой байх.

Ер нь углуургаар нь бол Сангийн яамны хувьд бол энэ асуудлуудыг шийдэх гээд бол бид ажиллаад эхэлчихсэн байгаа. Энэ бол юу вэ гэхээр бол бид нар аккюрил суурь руу л шилжих асуудал байгаад байгаа юм. Энэ зарлага гарч байгааг бид нар шууд зарлага гэж бичээд орлоготойгоо мөргүүлчхээд байгаа юм. Гэтэл энэ чинь мөнгөн хөрөнгөөс.

Н.Наранбаатар: Нэг минут нэмж хариулъя.

М.Санжаадорж: Тэгэхээр энэ хуулийг бид нар энэ төсвийн харилцаагаа тооцооллын бүртгэлийн энэ агуулгаар нь өөрчлөх асуудлыг эхлүүлж байгаа юм энэ жилээс. Гэхдээ энэ 5, 6 жил явах гээд байгаа юм. Энэ өөрөө 4300 орчим байгууллага дээр. Манай хувийн компаниуд бол энийг бараг арваад жилийн өмнөөс эхлээд одоо олон улсад IPO-ээ гаргаад эхэлчихсэн. Яг энэ систем рүүгээ орчихсон учраас хөрөнгөө өөрөөр хэлбэл баталгаа болгож гарч байна гэсэн үг. Манай төвд бол мөнгөн хөрөнгөөр гарснаа бүртгэххээд энэ чинь хөрөнгийн шинжээд үл хөдлөнгүй болчихоод байхад энэ хэсгийнх нь бүртгэл нь санхүүгийн тайлан болон төсвийн тайлан нь өөр тусдаа гарчхаад байгаа юм. Тэгээд энийг нэгтгэж олон улсын юу руугаа орох зүйлийг бид нар эхлүүлчихсэн. Гэхдээ 5 жил энэ төслөө бид нар

гацаагаад хөдлөхгүй байж байж болохгүй учраас энэ удаадаа заавал энэ нэг удаагийн шинжтэй хуулиар ингэж оруулж ирчхээд яг төслийн нэрээ зааж өгөөд энүүгээрээ хязгаарлаад явах нь зүйтэй байна гэж үзээд байгаа юм. Урт хугацаанд яг гишүүний хэлдэг тэр том төслүүдийг дахиад цаашдаа бид нар хэрэгжүүлээд явахад яг энэ төсвийнхөө юундаа оруулж ирээд тооцоогоо оруулж ирээд.

Н.Наранбаатар: Батболд гишүүн асуулт асууя.

Р.Батболд: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Гадаадын зээллэг энэ ашиглалттай холбоотой асуудлыг гишүүн болсноосоо хойш л санаа тавиад л асуугаад л яваад байгаа. Жил хагас өнгөрчихлөө. Тэгээд яах вэ ер нь зээлийнхээ ашиглалтыг яаж сайжруулах тал дээр бид нар нэг зохицуулалтынхаа асуудлыг л хурдан хийж авахгүй бол яг нэг иймэрхүү байдалтай анхдагч хууль гэдэг юм уу энийгээ дагаад дахиад л нэг бизнесийн зээл, бизнестэй холбоотой ийм хуулиуд орж ирээд байх ийм эрсдэлтэй л болоод байгаа юм.

Тэгэхээр Батжаргал гишүүний бас нэг гаргаад байгаа энэ хөгжлийнхөө банкныг ажиллуулаач гэдэгтэй санал нэгдээд байгаа юм. Ер нь өнөөдөр хүртэл зохицуулалтаа хийж чадаагүй учраас энэ орж ирж байгаа анхдагч хуулийг ер нь дэмжиж байна. Тэгэхдээ энэ төслийг нь хараад дэмжиж байгаа юм шүү дээ.

3.1, 3.2 дахь төслийг. Газрын тос боловсруулах үйлдвэр одоо энийгээ бид нар мөнгийг нь гаргаад бушуухан шиг барихгүй бол хугацаа нь угаасаа тулчихсан болохгүй байгаад байдаг. Төсвийн багтаамж маань зарлага маань болохгүй байгаад байдаг. Тэгэхээр яалт ч үгүй 1 удаагийн хуулиар ч юм уу ингээд нэг зохицуулаад явчих боломж байгаа юм уу гэж хараад байгаа юм.

Хоёр дахь нь ялгаа байхгүй Эрдэнэбүрэнгийн ингээд усан цахилгаан станц. 3.3 дахь тэр Сэлбэ дэд төвтэй холбоотой асуудлыг ерөөсөө дэмжихгүй. Ийшээ ингэж энэ хууль руу оруулмааргүй байгаа юм. Яахаараа энэ зүгээр ингээд бизнесийн зарчмаараа явах боломжтой юмыг төр нь орж ирж бонд гаргаад ингээд энийгээ зарцуулах гээд бид нар чадахгүй байна наад мөнгөө тавьж өг гээд хуульд оруулаад ингээд явж байдаг юм. Ийм юм байж болохгүй шүү дээ. Энэ чинь би бүтнээр нь биш энэ 3 дугаар асуудлыг нь яриад байна шүү. Тэгээд төсөвт өртөг нь өндөр нөгөө Сэлбийнх нь. Төрийн хийж байгаа ажил дандаа нэг иймэрхүү юм болдог. Одоо энэ төсөвт өртөг нь хэд болсон бэ 1м2 нь гэдгийг бас энэ нийслэлийнхэн хэлээд өгмөөр байна.

Дандаа энэ зээл тусламжаар хэрэгжиж байгаа энэ орон сууцын төслүүд байдаг юм уу юу байдаг юм. Энэ том том хорооллын төслүүд чинь дандаа төсөвт өртөг нь өндөр. Яагаад ингэж явдаг юм. Зүгээр бизнесийн байгууллагадаа зээлийг нь өгөөд эс үгүй бол хийлгээд явж болдоггүй юм уу? Хувийн ААН-үүд чинь 3.5 саяар метр квадратыг нь зараад болж байсан юмыг та бүгдийн оруулж ирсэн юм чинь 4.5-аас дээш болчихоод тэгээд дандаа энэ захын дүүргүүдэд тэгээд орон сууцын чинь үнэ өсөөд байдаг. Энийг чинь дагаад л өсөж байгаа шүү дээ. Төрийн хийсэн энэ бүтээн байгуулалт чинь өөрөө өртөг өндөртэй болохоор дагаад хувийнхан чинь өсгөж л таараа шүү дээ. Энэ дээр нийслэлийнхэн нэг хариулт өгмөөр байна. Зүгээр хуулийн хувьд бол энэ Алтаншагай гишүүнээс тэр 3.3 дахь хэсгийг хасчхаж болохгүй юм уу гэдэг зүгээр саналтай байна. Ийм ганцхан л асуулт байна надад дээр. Тэр бизнесээр зүгээр явж байгаа юмыг төр оролцчихоод тэгээд бид нар.

Н.Наранбаатар: Нийслэл хэдэн номер юм? 6 номерын микрофон.

Т.Даваадалай: Батболд гишүүний асуултад хариулъя. НЗД-ын 1 дүгээр орлогч Даваадалай. Сэлбэ дээр метр квадратын үнэ бол одоо нэг зардал сүүлийн шинэчилсэн байдлаар 1м²-тай нь 3 сая 950 мянга орчим болж байгаа. Бид нар борлуулах үнээ 4250 төгрөгөөр 1м²-ыг нь 2026 оноос борлуулахаар тооцож байгаа. Тухайн үеийн зах зээлийн судалгаагаар хийх юм бол шинэ орон сууцын үнэ 5.1-ээс 5.3 байхаар тухайн үед төлөвлөгдөж байгаа учраас энэ өрсөлдөх чадвар сайтай байна гэж үзээд Сэлбэ дээр ингээд тооцоолоод явж байгаа. Бид нар яах вэ сүүлд ажлын зураг барилга угсралт эхлэхээс өмнө зураг дээр өөрчлөлт хийгээд 10 мянга 63 айл 498 мянган ашигтай талбай байсныг 8575 айл болгож 535 мянган ашигтай талбай болгож өсгөсөн. Дундаж метр квадрат бол 61.72 м²-аар 1-ээс 3 өрөө, 32.8-89.1м²-тай байхаар тооцоолсон. Яагаад хувийн хэвшлүүдтэй өрсөлдөөд Сэлбэ дээр нийслэл орон сууц бариад байна вэ гэдэг дээр яах вэ энэ дээр 2 шалтгаан байж байгаа.

Нэгдүгээрт энэ бүхэл бүтэн хот учраас энэ 500 сая долларын бондын хөрөнгө оруулалт дээр орон сууцаас гадна шугам холбоо магестрал дулааны асуудлууд нийтийн эзэмшлийн гудамж талбай гээд ингээд хот босох хэмжээний бусад дэд инженерийн байгууламжийг нийт энэ 48 багцад хуваагаад эхний 12 нь болохоор инженерингийн дэд бүтэц байгууламжууд, бусдууд нь болохоор нийгмийн дэд бүтцүүдийг бид нар орон сууцжуулалтын тухай хуулиар бол хувийн хэвшлээр бол шалгаруулахаар ингээд бэлтгэлийг хангаад ажиллаж байгаа.

Анхны ийм 20 минутын хот агаарын бохирдлыг бууруулж байгаа. Хөрсний бохирдол, түгжрэл гээд ингээд аягүй олон асуудлыг багцаар нь шийдэж байгаа учраас зөвхөн орон сууцад ороод байгаа хөрөнгө оруулалт биш. Энэ гадна шугам хоолой, нийтийн тохижилт, үерийн байгууламж, усан толио гэх мэт инженерингийн бусад байгууламжид орж байгаа зарцуулагдаж байгаа хөрөнгө оруулалт гэж тооцож болно оо. Ийм учраас бид нар жишиг анхны 20 минутын хот байгуулж инженерийн дэд бүтэц 157 га дээр бүхэл бүтэн хот байгуулж байгаа учраас л ингэж зохион байгуулсан.

Цаашид бол нийслэл орон сууц дээр хөрөнгө оруулалт гаргаж болох ажлууд хийхгүй. Харин орон сууцжуулах тухай хуулиар сонгон шалгаруулалтыг хийж эхлүүлэхээр байж байгаа. Саяхан бид нар Ханын материал дээр 3 мянган айлын орон сууцжуулахыг хувийн хэвшлийн зардлаар нь хийлгүүлэхээр нийслэл газрыг нь чөлөөлөөд дэд бүтцүүд дээр нь хөрөнгө оруулалт хийхээр ингээд сонгон шалгаруулалтыг 11 сард эцэслэж хийгээд ингээд явж байгаа. Баярлалаа.

Н.Наранбаатар: Алтаншагай гишүүн. Батболд гишүүнд баярлалаа. Энэ Сэлбэ дэд төв маань Улаанбаатар хотод хийгдэж байгаа хамгийн анхны гэж хэлж болно. 1990 оноос хойш хийгдэж байгаа төр оролцож нийслэл өөрөө бонд гаргаж санхүүжилтээ босгож хийгдэж байгаа ийм хороолол. Энэ бол өөрөө та хотоос сонгогдсон хотод байдаг байна гээд гадарлаж байгаа байх. Гэр хорооллын агаар орчны хөрсний болон орчны бохирдлыг бууруулах мөн түгжрэлийг бууруулах гээд ийм хийгдэж байгаа томоохон төсөл хөтөлбөр. Нэгэнт мөнгө нь босож хийгдсэн учраас энэ бас цаг хугацаа алдалгүй энэ ашиглалтыг нэмэгдүүлж хугацаанд нь оруулъя гэсэн үүднээс нэг хуулийн төсөл дээр орж ирсэн.

Тэгэхээр энэ дээр бол одоо Улаанбаатар хотын иргэдэд мөн тэр 2040, 2050-д орсон хөтөлбөрүүдэд тусгагдсан томоохон зорилтуудын хүрээнд энэ багтсан хөтөлбөр учраас оруулж байгаа юм гэдгийг давхар хэлье. Тэгээд энэн дээр хуулиас татна ч гэсэн ойлголт байхгүй. Тэгээд энүүгээр нь явуулаад богино хугацаанд энэ орон сууцаа ашиглалтад оруулах энэн рүүгээ л явсан нь дээр байх гэж бодож байна.

Н.Наранбаатар: Батболд гишүүн тодруулъя.

Р.Батболд: Та нар ингэж яриад байгаа байхгүй юу? Нийслэл ийм сонин юм яриад байгаа юм. Анхнаасаа 2500 айлын гэр хашааг буулгачхаад тэгээд 10063 айл тэнд байлгана гээд ингээд ийм юм хийчхээд тэгээд тэр нь наад 152 гагийнхаа хэдэн хувьд нь ч 30 хувьд нь ч билүү ингээд байна гээд ингээд. Тэгсэн мөртөө төвлөрөл саарна гээд байгаа юм. Тэр айлууд чинь яах юм? Бүгдээрээ унаа тэрэггүй ч байдаг юм уу тэгж явах юм уу? Эс үгүй бол автобус унаагаар явах юм уу? Ийм нэг сонин юм. Зүгээр нийслэлээс асуух юм байна.

Анхан энэ төсөв ингээд яг энэ гадаадын зээлтэй холбоотой ингээд явж байхад та нар энэ газар чөлөөлсөн төлбөр, дээрээс нь энэ дэд бүтцийн асуудлуудыг тусгахгүйгээр энэ чинь бараг 3 сая 800 шахуу болчихоод байна гэж яриад байсан. Тэр чинь хэвээрээ байна уу эс үгүй бол тэр чинь орчихоод 4250 болоод байна уу?

Н.Наранбаатар: Батболд гишүүн нэмж нэг минут.

Р.Батболд: Энийгээ нэг хэлээд өгчихмөөр байна.

Ер нь наадах чинь бид нар дэд бүтцээ барьж өгчхөөд л бизнесийнх нь байгууллагууд байшингаа барьж байвал болно гэж ойлгоод байгаа юмыг та хэд байшинтай юутай ийтэй нь өгчхөөд. Тэгээд тэр 1, 2, 3, 4 дүгээр багцууд чинь бүгдээрээ дандаа Хятадын компаниуд орж ирээд үндэсний бүтээн байгуулагчид чинь байхгүй бөөн хэл ам болж байж 3, 4 чинь нэг юм дахиад нэг тендер зарласан шүү дээ. Энэ чинь ер нь ингээд яваад байх юм уу? Нийслэл ер нь гэдэг л асуудал байгаа. Тэгэхээр би бол энэ 3.3-ыг яах ёстой юм. Хасъя гэвэл энэ зарчмын зөрөөтэй санал гаргах юм уу яах ёстой юм. Тийм нийслэл тэрийг нэг хариулаад өгчих.

Н.Наранбаатар: 6 номерын микрофон.

Т.Даваадалай: Батболд гишүүний асуултад хариулъя аа. Засаг даргын 1 дүгээр орлогч Даваадалай. Газар чөлөөлөлтийн үнэ ороогүйгээрээ бид нар 3950 гээд тэгээд борлуулах үнийг бол бид нар 4250-аар тооцож байгаа. Төсөл алдагдалгүй болно. Түрүүний хэлсэнчлэн зөвхөн барилга биш энэ чинь нөгөө дэд бүтцүүдийн багцууд дээр их зардал гарч байгаа гэдгийг бас үүн дээр болохоор хөрсний усны ус хангамжийн байгууламж гол магистралууд дулаан гээд ингээд 12 үндсэн багц дээр инженерийн байгууллагууд хуваагдаад зардлууд гарч байгаа гэж нэмэлтээр хариулъя аа.

Н.Наранбаатар: Хэдэн номер 5 номер нэмж хариулъя.

М.Үнэнбат: Батболд гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Үнэнбат. Энэ Алтаншагай гишүүний өргөн барьсан төсөл дээр нэг зарчим барьж орж ирж байгаа гэж харж байгаа. Юу байна вэ гэхээр энэ бол 500 тэрбум төгрөгөөс дээш санхүүжилтийн 3 том төсөл байгаа.

Энэ том төслийн цаад талын зорилго, хуулийнх нь зорилго юу байна вэ гэхээр хэрвээ энэ 3 том төслийг энэ Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан энэ хуулийн өрийн хязгаарын асуудлаас ингээд тооцохгүй гэж тооцох юм бол энийг дагаад өнөөдрийн байдлаар нийт 89 төсөл арга хэмжээ, 17 төслийн хэлэлцээртэй холбоотой төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа. Эд нарын санхүүжилтийн гүйцэтгэл нь сайжраад, хугацаа нь наашлаад явна гэдэг ийм зорилго байна уу гэж харж байгаа.

Энэ дээр Сэлбэ орж ирснээрээ энийг Сэлбийг ямар нэгэн байдлаар энийг ингээд оруулаад ирснээр нөгөө талдаа Сэлбийг өрийн асуудлаас гаргана гэсэн ийм асуудал байхгүй. Энэ өрийн удирдлагын хуулиар зохицуулагдаад 500 сая долларыг аваад бид нар нийслэл 2027 оноос эхлээд буцаагаад өрийг төлнө. Тэгэхдээ энэ өр төлөхдөө бол худал.

Н.Наранбаатар: Номин гишүүн асуулт асууя.

Ч.Номин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Нэгдүгээрт энэ хуулийг бол нэг удаагийн чанартай, мэдээж нийгмийн төслөөс илүүтэй эдийн засгийн эргэлтэд өгөөжтэй тэгээд дээрээс нь томоохон төсөл арга хэмжээнд эрчимжүүлэх зорилготойгоор оруулж ирж байгаа гэж үзэж байгаа учраас дэмжиж байгаа.

Дээрээс нь хамгийн гол агуулгаараа энэ дээр хэлчихсэн байгаа. Нийт манай 17.9 их наяд төгрөгийн боломжоос 29 хувь нь л эргэлттэй байгаа. Тэгээд энэ томоохон төсөл арга хэмжээндээ явуулах гэж оруулж ирж байгаа гэж үзэж байгаа. Би Батболд гишүүнд бас Сэлбэ дээр та ийшээгээ Чингэлтэй рүү гараад Сэлбийн ийшээ гараад явбал энэ нийслэлийн бүтээн байгуулалтууд маш эрчимтэй явж байгаа. Одоо бүүр эхнээсээ барилгууд нь баригдаад эхэлчихсэн. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны жишиг болох хэмжээний ийм зүйлүүд явж байгааг та нэг гараад харвал их зүгээр санагдсан. Яагаад би энийг онцолж хэлээд байна вэ гэхээр энэ чинь хуучин гэр хорооллуудыг дахиад газарт оруулаад хэлэлцээрт ороод дахиад шинэ төрлийн барилгууд орж ирж байгаа.

Тэгэхээр энэ бол бид нарт яваандаа хамгийн гол нь өнөөдрийн энэ нийслэлд тулгамдаад байгаа утааны хэмжээг бууруулах гэх мэтчилэн ийм зүйлүүдэд хамгийн чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа учраас энэ төсөл дээр заавал байх ёстой болов уу гэж бодож байгаа гэдгийг хэлье гэж бодож байна. Зүгээр миний зүгээс яах вэ энэ дээр ер нь ийм эдийн засгийн мөн чанартай төслүүдийг бол нэгэнт энэ чинь буцаад өөрсдөө орлого олоод зээлээ төлчих боломжтой зүйлүүдийг бол энэ Хөгжлийн банкаараа л уг нь дамжиж явах ёстой. Гэхдээ түрүүний хэлсэн энэ үндсэн шалтгаан буюу зээлийн ашиглалт бага байгаа учраас л томоохон төслүүдээ эрчимжүүлэхийн тулд оруулж ирж байгаа юм байна гэж ойлгож байгаа. Энэ утгаараа 3 асуулт байна. Дахиж ийм нэг удаагийн чанартай хууль оруулж ирэх нөхцөл үүсэх үү? Эндээс үзэхэд далан хэдэн төсөл арга хэмжээ байна шүү дээ тиймээ? Түрүүн бол яах вэ мэдээж тэр акюар суурьтай явна гэдэг бол аягүй зөв шийдэл юм шиг харагдсан.

Хоёр дахь нь болохоор яг ингэж явснаар ямар эрсдэл та нар харж байна аа? Одоо ингээд нэг удаагийн хууль баталж явснаар та нар ямар эрсдэлийг харж байна? 3 дахь асуулт болохоор яг энэ 3 төслүүд маань ямар явцтай хэдэн хувийн явцтай

явж байгаа, энэ санхүүжилтээ авснаар хэрэгжилт дээр ямар давуу тал үүсэх вэ? Хурдасгах боломж байгаа юу? Ийм 3 асуулт байна.

Н.Наранбаатар: Сангийн яам эхлээд хариулъя. Индрийн микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр 1 дүгээрт бол бид дахиж бол ийм хууль бол гарах шаардлагагүй гэж үзэж байна. Яагаад гэхлээр бид нар нөгөө төсвийн энэ бүртгэлийн системээ өөрчлөх ажил маань бол эхэлчихсэн явж байгаа. Цаг хугацааны хувьд бол бид нар төсвийн дунд хугацаанд буюу 4-өөс 5 жилийн дотор энийгээ эцэслээд орно гэсэн тийм зорилт тавьж байгаа. Тэгэхлээр бол дахиж ийм хууль гарах шаардлагагүй болно.

Өрийн хувьд бол энэ зээлийн хэлэлцээрийг энэ төслүүдийг хэрэгжүүлэхдээ Улсын Их Хуралд танилцуулж зөвшөөрлөө авч явахдаа бүгдээрээ өөрийнх нь тоондоо орчихсон тоонууд байгаад байгаа юм. Тийм тэгэхлээр бол бид бол өрийг энэ зээлүүдийг илүү хурдан ашигласнаар бол тэр хэмжээгээрээ манай өрийн хэмжээнд бол эрсдэл учрах бол тийм эрсдэл байхгүй. Хамгийн гол асуудал бид нар бол нийгэм, эдийн засагтаа үр шимийг нь хурдан аль болох хүртэх ийм асуудал байгаад байна.

Н.Наранбаатар: 7 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Номин гишүүний асуултад хариулъя.

Сангийн яам Дэлгэржаргал. Гадаад зээлийн хувьд ер нь 2024 оноос эхлээд бид нар нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй нөхцөлтэй ийм зээлүүд авах боломжгүй болсон. Одоо ер нь цаашдаа бид нар зээл гадаад зээлийн эх үүсвэр авах юм бол арилжааны арилжааны нөхцөлтэй. Энэ утгаараа одоо байгаа гадаад зээлийн эх үүсвэр өөрөө хязгаарлагдмал болоод ирж байгаа. Монгол Улс өөрөө донор орны тоонд ингээд ороод эхэлж байгаа. Тэгэхээр гол асуудал одоо яг Улсын Их Хурлаас соёрхон баталчихсан энэ зээлүүд бол ихэнх нь нэн хөнгөлөлттэй, хөнгөлөлттэй. Дээрээс нь зээлийн төслүүд нь тусламжийн эх үүсвэртэй ийм хосолмол.

Тэгэхээр энэ нь бол манай эдийн засгийн хувьд томоохон төслүүдээ ашиглалтад оруулах хөгжлөө дэмжихэд маш чухал түлхэц болох асуудал байгаа учраас газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд бол Монгол Улс анх удаа ийм 6 их наядын гадаад зээл авсан байгаа түүхэндээ. Тэгэхээр энэ өөрөө яг энэ төслийг энэ хуулиар зохицуулснаар бусад төслүүдийн хувьд бол нөлөөлөл нь бусад төслүүдээ зээл төсөв талдаа яваад ашиглаад явахад хугацаандаа ашиглаж орох боломж бүрдэх ийм давуу талтай байгаа.

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх энэ анхдагч хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байна аа. Энэ ерөөсөө л Улсын Их Хурлын явуулж ирсэн, бодлогын үр дүн шүү дээ. Бид хэд өөрсдөө л ийм хуулийг гаргах нөхцөлийг Улсын Их Хурал өөрөө бүрдүүлсэн. Энэ төсвийн зарлагын хязгаарыг мэдсээр байж байж л энэ байгаа төсвийнхөө хайрцгийг мэдсээр байж байж л зээлийн хэлэлцээрүүдийг бид соёрхон батлах эрхийг одоо ч өгсөөр байгаа шүү дээ.

Одоо ч өгсөөр байгаа. Зээлийн хэлэлцээр болгоны цаана дандаа хууль байгаа. Нэг хууль гаргаж нөгөө хуулийн хэрэгжилтийг зогсоож болохгүй байхгүй юу.

Тэгэхээр энэ түгжигдчихээд байгаа энэ зүйлүүд дээр Сангийн яам маань цаашдаа суурь реформ хийж байгаа юм байна. Энэ хууль шилжилтийн үеийг нь дэмжиж өгөх юм байна. Цаашдаа дахин дахин ийм хууль ерөөсөө гаргаж болохгүй. Тэгэхээр би яах вэ явж ирсэн өнгөрсөн энэ 20, 30-аад жилийн түүхэнд ийм агуулгатай, ийм зохицуулалттай хууль ер нь гарч байсан уу? Энийг бас нэг хэлж өгөөч. Би бол бас Алтанхуяг гуайн Засгийн газрын үед нэг гарч байсан гэж ойлгоод байгаа зөв үү?

Тэгэхээр энэ асуудлыг нэг тодорхой хэлж өгөөч? Түүхэн талаас нь.

Хоёрдугаарт газрын тосны үйлдвэрийг барьж ашиглалтад оруулах нь бидний бүүр ингээд маш чухал том амбиц байх ёстой. Энэ үндэстнээрээ энэ дээр ямар нэгэн үл ойлголцол хоёрдмол утгагүйгээр зүтгэхээс өөр арга олно шүү дээ. Өнөөдөр ингээд л гараад л нийгэм дээр хэдэн цагаар бензинд очерлож байна. Энэ зээлийн ашиглалтын хязгаарт багтаагаад явах юм бол энэ газрын тосны үйлдвэр чинь хэзээ орох юм? Тэгээд л нэмээд л бид нар нэмэлт санхүүжилтийн зээлийг нь саяхан батлаад л өгсөн шүү дээ. Хавар байх. Тэгээд ингээд 6 их наяд авчхаад байдаг жилд зарцуулалтад 1.7 их наяд шаардлагатай байхад 200 тэрбумаар өгчхөөд. Хаагуураа төсвийн болоод бусад хууль тогтоомжийг зөрчиж энэ санхүүжилтийг олгож байгаа бол доо? Олгож байгаа шүү дээ. Тэгээд хэдүүлээ ийм бие биеэ хуурсан байдлаар ингээд явмааргүй байна аа. Тэгээд энэ хууль гарснаараа 8 дугаар зүйл дээрээ байна.

Хуулийн хэрэгжилтийн талаар тайланг тухайн жилийн төсвийн гүйцэтгэлтэй хамтаар оруулж ирэх юм байна. Бид хяналтаа алдах гээд байгаа зүйл ерөөсөө алга. Газрын тосны үйлдвэр барилаа гээд жилд энэ ашиглалтад орох хугацааг мэдээж яг энэ төлөвлөгөөний дагуу графикайн дагуу наашлуулж авчрахаасаа гадна Монгол Улсаас гадагшаа гарч байгаа 1 их наяд ам.долларын валютыг эх орондоо авч үлдэх энэ нөхцөл байдлыг л шуурхай бүрдүүлэх гэж байна гэсэн үг. Энэ бол харин эх оронч хууль байхгүй юу. Эх оронч хууль.

Хоёрдугаарт Эрдэнэбүрэний УЦС яах вэ зүгээр энэ хүчин чадлын энэ ТЭЗҮ, зураг төсвөөрөө бас яг хүрч ажиллаж чадахгүй юм шиг байна. 90 мвт гэж байгаа мөртөө тэр уулын техникийн нөхцөл байдал энэ тэрийг хараад уул нүхэлж орж ирээд далан барихгүйгээр орж ирээд хийж байгаа энэ юугаар гэхээр нэг 45-50 л юм шиг байгаа юм. Тэгэхдээ л манай баруун бүсийнхэнд хэрэгтэй байна. Эрчим хүч хэрэгтэй байна. Эрчим хүч бий болж байж хямд эх үүсвэртэй найдвартай эрчим хүчний эх үүсвэртэй болж байж. Хариултаа авчихъя. Ийм маягийн.

Н.Наранбаатар: Сангийн яам хэдэн номер вэ? Индрийн микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Өмнө нь бол яг ийм агуулгатай тусгайлан төсөл заасан бол хууль бол гарч байгаагүй байх аа. Би тэрийг танд нягталж үзэж байж хэлэхгүй бол болохгүй байна. Ер нь бол агуулгын хувьд бол яг гишүүний хэлж байгаа санал дээр хэлэхэд бол энэ өөрөө юу гэдэг юм манай төсөв маань бол өөрөө ингээд мөнгөн суурьтай нэг талаасаа бол ард иргэдийн хувьд бол төсөв тэлэхгүй гээд байдаг. Гэтэл энэ мөнгө маань өөрөө зарцуулахад бэлэн ороод ирчихсэн. Үр шимийг нь л хүртэх

шаардлагатай байдаг. Тэгээд алдагдлаараа бид нар ингээд бүх төсвөө ингээд хайрцаглачихсан.

Гэтэл эдийн засгаа бид нар ингээд огцом хугацаанд богино хугацаанд ингээд дэмжих ийм төслүүдийг хэрэгжүүлбэ гэхлээр яг энэ хүрээгээрээ төсвийн хэмжээгээр хязгаарлагдах юм бол бид нар чадахгүй. Тийм учраас мөнгөний бодлогын хэмжээнд бид нар ямар байдлаар эдийн засгаа богино хугацаанд тэлж чадах вэ ямар хэмжээний том төслүүдийг бид нар богино хугацаанд явуулж чадах вэ гэдэг энэ зүйлүүдээ л бол бид нар сайн харах нь бол зүйтэй байна гэж бол хараад байгаа. Цаашдаа бол одоо яг энэ нэг удаагийн шинжтэй хууль бол яг шилжилтийн үед гарч байгаа ийм хууль байгаа учраас бол нэг удаадаа орж ирнэ. Цаашдаа бол орж ирэх шаардлагагүй байна гэж бол миний хувьд үзэж байгаа.

Сангийн яамнууд бол төлөвлөгөөгөө баталчихсан байгаа. Сангийн сайдаар бол яг төлөвлөгөөгөө батлуулаад энэ горим руу шилжих ийм зүйл дээр орохоор байгаа. Энэ акюрал суурь дээр бол хувийн хэвшлүүд ихэнх том компаниуд орчихсон байж байгаа. Манайх нөгөө улсын секторын буюу Монгол Улсад байж байгаа бүх нягтлан бодох бүртгэлийн секторын юуг батлахыг бол үндсэндээ манайхыг нөгөө талдаа хувийн хэвшил маань хүлээж байгаа ийм зүйл болчхоод байгаа гэдгийг тодруулж л байж байгаа юм.

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүн нэмж асууя.

П.Сайнзориг: Тэгээд ойлголоо. Гол асуудал ерөөсөө цаана нь энэ 3 төслийг яах вэ тодорхой хэмжээний ийм хайрцгийн бас нэг хоёрдогч хайрцаг руу оруулж байгаа бусад тэр 86 төсөл чинь хөдлөөд нийгэмд үр өгөөж энэ авчраад нэгэнт бэлэн байгаа. Шинээр зээл авах гэж байгаа зүйл нэг ч байхгүй гэдэг нийгэм олон нийтэд зөв ойлгуулмаар байна. Энэ байгаа авчихсан зээлээ бид хэд хурдан ашиглаж хурдан энэ төслүүдийнхээ үр өгөөжийг хүртбэ л гэдэг гол зорилго агуулга байгаа шүү гэж хэлж байгаа юм. Тэгээд энэ ашиглалт сайжрахгүй болохоор ерөөсөө ийм юм байна лээ. Солонгосын ерөнхийлөгч айлчлаад нэг төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд явсан. 2007 айлын орон сууц барих гэж байсан. Энэний ашиглалтыг одоо хүртэл энэ төсвийн бодлого дээр явсан чинь ямар ч байсан энэ удаашрах тусам тэр гадна тохижилтууд нь байхгүй болсон юм байна лээ. Яагаад гэхээр мөнгөний ханш, инфляц, бараа материалын үнийн өсөлт ч байдаг юм уу ийм зүйлүүдээсээ болоод зээлээ ашиглаж чадахгүй чадахгүйгээр хийнэ гэж байсан 10 ажлын нэг нь бага багаар цаг хугацаа өнгөрөх тусам алга болоод байгаа байхгүй юу. Өртгийг нь бид нар угаасаа төлнө.

Тийм учраас энийг одоо.

Н.Наранбаатар: Нэмж асууя нэг минут.

П.Сайнзориг: Тэр утга талаас нь зөв ойлгоосой гэж би гишүүдийгээ олон нийтийн хувьд хүсэж байна. Нийслэлийн хувьд одоо энэ агаар, орчны бохирдол, хөрсний бохирдол ямар хэмжээнд байгаа билээ. Энэ бол 1 дүгээр үе шат дээр нь нийслэл оролцож байгаа.

Хоёрдугаар үе шатан дээрээс энэ газрыг эдийн засгийн эргэлтэд нь оруулаад яг дэд бүтэцжүүлээд орон сууц болон тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх дэд бүтэц нь холбогдсон ийм газруудыг хувийн хэвшил дуудлага худалдаагаар олон нийтэд

санал болгох байдлаар явж байгаа. Өмнөх энэ газар чөлөөлөлтийн асуудал чинь фийлдчихсэн байхгүй юу. Орц орцоор нь бариад. Угаасаа хувийн хэвшилд маань ийм хэмжээний чадавх алга. Тэгээд энийг тодорхой түвшинд нийслэл өөрөө оролцож байж энэ хэмжээний нийгэм Улаанбаатар хотод тулгамдчихаад байгаа асуудлуудыг зөв эхлүүлье л гэж байгаа юм. Энийг үргэлжлүүлээд дандаа байшин барих гээд байгаа зүйл ерөөсөө байхгүй. Эхний алхмыг нийслэл өөрөө оролцоотой байж байж энийг авч гарахгүй бол нэг фийлдвэл бас хэцүү байгаа юм.

Тэгээд 2 дахь раундаас буюу 6 буудал, 7 буудал, Дэнжийн мянгаас эхлээд энэ дэд бүтцийг нь татаад хувийн хэвшил өөрсдөө яг төлөвлөлтийн дагуу бариад эхлэх юм байгаа юм. Ийм л агуулгатай. Үг хэллээ.

Н.Наранбаатар: Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Алтаншагай гишүүнийг зөвөөр ойлгож байна аа. Хууль санаачлаад энэ гацаад байгаа асуудлуудыг дэмжихийн тулд явж байгаа гэж. Гэхдээ энэ хамтарч оруулж ирж байгаа нийслэл байна, Сангийн яам байна, Эдийн засаг, хөгжлийн яам байна. Ажлынх нь уялдаа холбоо үнэхээр харагдахгүй байгаад байгаа юм. Батжаргал гишүүн энэчээнээс маш зөв зарчмын байр суурь илэрхийлээд байгаа. Энэ Хөгжлийн банкаа ашиглалтад оруулаад ажиллаад ашиглаад яваач гээд. Хөгжлийн банкаа ашиглаад явах юм бол бид нарт маш олон эрсдэл хаагдана. Адаглаад л нийслэл өөрөө шууд 500 сая долларын зээл авч байлаа гэхэд ханшийнх нь эрсдэлийг нийслэл өөрөө хүлээнэ. Тэнчээ чинь Хөгжлийн банк мэргэжлийн байгууллага ханшийн эрсдэл хүлээж чадна. Шаардлагатай бусад эрсдэлүүдийг хяналтуудыг сайжруулна, эрсдэлийг бууруулна гээд явж байгаа ийм бүтэц төрд нь байсаар байтал тэрийгээ ашиглаж чадахгүй байгаа. Тэгээд Нийслэлийн энэ асуудлыг Сэлбэ дэд бүтцийг түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл гээд орж ирж байгаа нь бол жишээлэхэд Зам, тээврийн яам энэ Богд уулын урд талаар энэ төмөр замынхаа асуудлыг шийдээд явчхаж байхад нийслэл дахиад Туул гол дээгүүр зам барина. 2.7 их наяд. Энэ 2.7 их наядаараа бид нар энэ янданг бууруулахыг дэмжиж байна. Нүхэн жорлонг бууруулахыг дэмжиж байна. Утааг бууруулахыг дэмжиж байна.

Тэгээд энэ асуудал руугаа хийгээд явах юм бол одоо энэ хот дундуур явж байгаа энэ төмөр зам энэ тэр чигээрээ сулраад гараад ирэх боломжийг нийслэл ашиглахгүй. Зүгээр яг ингээд нэг ийм авна гэхихсэн, хэлнэ хийнэ гэхихсэн энэ амлалтыг чинь ойлгож байна дэмжиж байна. Гэхдээ та нар хоорондоо ажлаа уялдаа холбоог нь сайжруулах юм бол ЗТЯ-аас Богд уулынхаа урд талын хэсгээр төмөр замыг гаргаад өгч байхад бид нар заавал гол дээгүүрээ зам барих шаардлагагүй. Хот дотор чинь дахиад нэг ийм урт трастай та нарын шаардлагыг бүрэн хангах хэмжээнийх нь зам сулраад байна шүү гэдгийг анхаарахгүй бол дахиад энэ чинь 2.7 их наядыг үрэх гээд байгаа юм.

Ер нь Сангийн яаман дээр энэ асуудлууд энэ гадаад зээлийн ашиглалттай холбоотой, гэрээнийх нь нөхцөл дээр бид нар маш муу сууж байгаагийн нэг илэрхийлэл нь Архангай аймгийн дулааны станцын асуудал. 2024 оноос хойш гацчихсан. Одоо үндсэндээ гацаад 2 жил болж байгаа. Гэтэл бид нар өнөөдрийг болтол л хүүг нь төлөөд л явж байгаа. 600 сая төгрөг хүүд нь төлөөд явж байгаа. Ингээд бага гэхгүйгээр бид нар уялдаа холбоо хяналтаа сайжруулж явж чадахгүй

байсны чинь гор нь энэ. Тэгэхээр энэ дээр бол бид нар Хөгжлийн банкийг маш сайн ашиглалтад нь оруулаад энэ хуулийг Алтаншагай гишүүнийг бол ойлгож байна. Тодорхой хэмжээний гацчихсан байгаа асуудлуудыг дэмжээд явж байгаа гэнэ. Гэхдээ газрын тос боловсруулах үйлдвэр намайг байхад л Хөгжлийн банканд дээр явж байсан төсөл одоо болтол дахиад хэмжээ нь өргөжөөд явж байна гэж харж байгаа.

Хөгжлийн банкаараа дамжаад явахад энэ дээр ямар ч асуудал гарахгүй. Энэтхэгийн Засгийн газраас бид нар зээлээ авч байна. Хөгжлийн банканд хийж байна. Хөгжлийн банк эрсдэлээ сайжруулж байна. Эрсдэлийг нь дахиад удирдаж байна. Хяналтыг нь сайжруулж байна. Энэ Засгийн газраас чинь бол энэ нэг ажлууд нь хийгдэж чадахгүй өнөөдрийг хүрчихсэн гэдгээ бид нар ойлгож байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар яг энэ Хөгжлийн банк руугаа түлхүү өгөөд явчих юм бол энэ эрсдэлүүдийг бид.

Н.Наранбаатар: Нэг минут нэмж өгье.

Да.Цогтбаатар: Эрсдэлээ багасгаад хяналтаа сайжруулаад явчих боломж байгаа. Энийг бид нар тухайлсан нэг хууль батлаад явахыг бол миний хувьд, зарчмын хувьд буруу гэж харж байгаа. Тэгээд энэ Сангийн яамнаас 10 аймгийн дулааны станцын талаар мэдээллээ авъя.

Н.Наранбаатар: Сангийн яам 7 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал.

Баруун аймгийн дулааны станцын хувьд бол яг энэ төслүүдтэй адилхан Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан Солонгосын Эким банкны хөнгөлөлттэй зээлээр явж байгаа. Тэгээд энэ дээр бол яг төслүүдийн хувьд манай гадаад зээлийн төслүүдийн хувьд нэг хууль эрх зүйн хувьд ийм зохицуулалт байдаг. Бид нар зээлийн хэлэлцээрүүдээ байгуулаад зээл авахдаа бол донор орны санхүүжүүлэгч талын шаардлага дотооддоо болохоор Өрийн удирдлагын тухай хуулиа бариад бид нар зээлээ соёрхон баталчихдаг. Яг хэрэгжилт болон худалдан авах ажиллагаа бол яг тухайн санхүүжүүлэгчийн дүрмээр явдаг. АХБ-ны зээл АХБ-ны худалдан авах ажиллагааны журам, Солонгосын 10 аймаг Эким банкны худалдан авах ажиллагааны журам.

Тэгэхээр энэ гүйцэтгэгч нь өөрөө анхны хэлэлцээр дээрээ Солонгос гүйцэтгэгч байна гэдэг ийм шаардлагын хүрээнд Эким банк өөрөө яг энэ гэрээ болон гүйцэтгэгч дээр зөвшөөрөл олгосон. Тэгээд хэрэгжилтийн ЕРС явцад ковидын үеийн үнийн өсөлт асуудлуудаас үүдээд гэрээ өөрөө нөхцөлтэй түлхүүр гардуулах ийм гэрээ байсан. Үнийн өсөлттэй үүдээд үндсэн гүйцэтгэгч компани дампуурсан. Тэгээд Солонгосын хуулиараа бол яг энэ шүүхийн процессууд яваад ингээд дампуурлаа зарласан байгаа. Үүнтэй холбогдуулаад ажлын хэсэг, Эким банк, Сангийн яам, ЭХЯ хооронд бид нар хэлэлцээрүүдийг байнга хийж байгаа. Одоогийн процесс бол үндсэн одоо энэ зээлийнх нь хэлэлцээрийн хугацаанд нэмэлт санхүүжилт үүсэхгүйгээр зээлийн хөрөнгө дээр дахин худалдан авалт зарлаад үндсэн гүйцэтгэгчийг шалгаруулаад төслийг яг ингээд хугацаанд нь дуусгах процесс явж байгаа. Нөгөө талд нь бид нар гүйцэтгэгч дампуурсантай холбогдуулаад гүйцэтгэлийн баталгааг ямар ч байсан Монголын Засгийн газар татаж аваад 5 сая ам.долларыг татаад авчихсан байгаа.

Урьдчилгаа төлбөрийг татаж авах дээр процессын ийм ажлууд явж байгаа. Эксим банк болон Эрчим хүчний яам Солонгосын санхүү эдийн засгийн яамтай бид нар хэлэлцээр хийгээд Солонгосын Эксимээс яг зөвлөх хөндлөнгийн зөвлөх компани шалгаруулаад одоо бүх аймгуудаар яваад тайлан нь яг эцэслэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл яг бодит ажил юу хийгдсэн. Яг энийг дуусахад яг хэдий хэмжээний хугацаанд ямар хөрөнгө шаардлагатай гэдэг энэ тайланг энэ зөвлөхийн зардлыг Эксим банк өөрөө санхүүжүүлээд ингээд тайлан гараад одоо энэ 12 сардаа багтаж бид нарт өгөх байгаа. Үүн дээр үндэслээд сонгон шалгаруулалтыг дахин сонгон шалгаруулалтыг энэ дүгнэлт дээр үндэслээд ирэх нэг сард зохион байгуулаад Монголын талаас тавьсан хүсэлт бол Солонгос компани биш. Энэ Солонгос компанийн туслан гүйцэтгэгч компаниуд нь Монгол компани байгаа.

Тийм учраас энэ Монгол компаниудаар үргэлжлүүлж энэ дуусгах хүсэлтийг өгсөн байгаа. Тэгээд энэ ажлыг үндсэн зохион байгуулаад дуусгах яам нь Эрчим хүчний яам байгаа.

Н.Наранбаатар: Алтаншагай гишүүн нэмж хариулъя. Яах вэ сая маш олон гишүүд байр сууриа илэрхийлж байгаа. Тэгээд энэ зээлийн ашиглалтын тухай хуулийг санаачилсан нь ганцхан л юмыг голчлон харж байгаа юм. Үр ашгийг нэмэгдүүлэх яаралтай ашиглалтад оруулах стратегийн 3 бүтээгдэхүүний 2 нь энэ дотор орчхоод байгаа юм. Эрчим хүч, нефть боловсруулах үйлдвэр гээд. Яах вэ таны тавьж байгаа шаардлагыг ойлгож байна аа. Гэхдээ өнгөрсөн хугацаанд бид бүхэн энэ зээлээ мөнгөө босгочхоод ашиглаж чадаагүй, хэрэгжүүлж чадаагүй өдийг хүрсэн. Тэгээд энэ саяын ярьсан томоохон төслүүдийг ашиглалтад оруулахын тулд л цаг хугацаа хожихын тулд л энийг ингэж барьж байгаа.

Тэгэхээр таны саналтай бас санал нэг байна аа. Энийг холбогдох яамд нь яг тусгаж аваад дараа нь үлдсэн энэ зээллэгийн том том төслүүд байгаа энэн дээрээ онцгойлон анхаарч явах нь зөв байна л гэж санал нэг байна аа.

Н.Наранбаатар: Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

Д.Үүрийнтуяа: Алтаншагай гишүүнд талархлаа илэрхийлье. Өнөөдөр төсөв дээр тулгамдаж байгаа асуудлыг шийдэхээр зориглож нэлээн асуудал татахаар зүйлүүдийг оруулж ирж байгаа нь талархалтай байна. Гишүүний хувьд. Хэд хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт газрын тосны үйлдвэр барих гэж байгаа энэ зээлийн гэрээ өнөөгийн төсвийн тусгай шаардлагын дагуу явах юм бол 10 жил шаардагдана гэж танилцуулгад орсон байна. 10 жил шаардахад бид нар энэ зээлийн ашиглаагүй зээлийн хүүгийн зардалд ашиглаагүй зээлийнхээ үлдэгдэл тутамд нь бид нар хүү төлж байгаа шүү дээ. Нийт ямар хэмжээний зардал гарахаар тооцоо гарч байгаа вэ? Нэг.

Хоёрдугаарт гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл 12.6 их наяд төгрөг гэж тооцоо гаргасан байна. Энд энэ Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн зээлийн дүн орсон уу?

Гуравдугаарт энэ Сэлбэ дэд төв гээд байгаа энэ орон сууцжуулах төслийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн дагуу хувийн хэвшилтэй хамтрах байдлаар

зохион байгуулж болоогүй юу? Нийслэлээс хариулахдаа тэр дэд бүтцийн асуудлууд орж ирж байгаа гээд байгаа юм. Тэгвэл энийг нь салгаад зөвхөн тэр дэд бүтэц, нийгмийн дэд бүтцийг нь хийхэд ямар хэмжээний зардал гарах гэж байгаа юм? Тэр нь нийт зээлийн хэдэн хувь болж байгаа юм?

Дөрөвдүгээрт энэ ирээдүй өв сан ер нь хэдэн төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хэдэн хувийн хүүтэй, хаана хадгалж байна? Нөгөө талдаа манай авч байгаа нийт гадаад зээл, дунджаар хэдэн хувийн хүүтэй байна? Энэ тодорхой хариулт асуултууд дээр хариулт авчихмаар байгаа юм. Яах вэ Сангийн яам энэ асуудлыг өөрчлөхийн тулд энэ төсвийн тух тусгай шаардлагад нийцүүлээд хөрөнгө оруулалтын асуудлуудаа зээлийн дүнг багтаагаад оруулахад бүртгэлээр бид нар өөрчлөлт хийхээр ажлыг эхлүүлж байна л гэж байна л даа. Тэгээд 6, 7 жил шаардах юм ярьж байна. Тэгээд магадгүй энэ зүгээр бүртгэлээр хийх нь нэг л арга. Тэгэхдээ их урт хугацаа шаардах ийм л арга байх. Зүгээр энэ яг хуулийн төслийг харахаар нэг удаагийн шинжтэй тэгээд л үндсэндээ нэг аргацаасан арга ядсан л хэлбэр шүү дээ. Нэг тийм оновчтой зүйл биш. Ийм зүйл гаргаад жишиг тогтоох нь цаашдаа хэрэгжүүлэх хэдэн төсөл дээр ийм хууль санаачлах вэ гэдэг рүү ч тулгана.

Тийм болохоор Хөгжлийн сан, Хөгжлийн банкныг ашиглах энэ гарц гаргалгаан дээр Сангийн яам хууль эрх зүйн өөрчлөлтийг хийх чиглэлээр ямар санал боловсруулж байгаа зүйл байна уу? Ямар саналтай байгаа вэ?

Н.Наранбаатар: Сангийн яам индрийн микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя аа.

Ер нь бол бид бол байгаа эх үүсвэрээ хэрхэн зөв оновчтой зарцуулах вэ яаж чиглүүлэх вэ гэдэг асуудал бол том глобал зургаараа бол энэ дээр харагдаж байна. Бидний хувьд бол өмнө нь бол яах вэ Хөгжлийн банкаар бол бид нар асуудлыг бол шийдэж явж байсан. Гэхдээ Хөгжлийн банкн дээр нэг зүйлээс нь бол нийгмийн шинжтэй ашиг олохгүй тийм төслүүд яваад байснаас болоод тэр маань өөрөө тийм нэг пийлдэх нэг шалтгаан болсон болов уу гэж харж байгаа. Одоо бол Сангийн яамны хувьд бол хууль, эрх зүйн хувьд бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийг бол бид боловсруулаад явж байгаа. Ялангуяа бол төсвийн шатлал хооронд буюу орон нутгийн төсвөөр, сумын төсвөөр, дүүргийн төсвөөр хэн нь юугаа хийх вэ гэдгээ маш тодорхой болгоод Хөгжлийн банкаараа юугаа хийх вэ гэдгийг тодорхой болгоод тэгээд улсын төсвийн хөрөнгө оруулалтаараа бид нар юугаа хийх вэ гэдгээ тодорхой болгоод ингээд үлдэж байгаа хэсэг буюу гадаад зээлийн эх үүсвэрээрээ бид нар ямар төслүүдийг ямар шинж чанартайг бид нар хэрэгжүүлэхийг зөв болгох вэ гэдэг энэ зүйлийг бол 1 дүгээрт хууль, эрх зүйн хүрээнд бол энэ хөрөнгө оруулалтын тухай хуулиар бол шийдэгдэж бол орж ирнэ гэж бол бид харж байгаа.

Процессын хувьд бол түрүүний нөгөө ярьж байгаа одоо бид нар бүртгэлийн энэ тогтолцоогоо өөрчлөх асуудал орж ирнэ. Энэ бол мэдээж хэрэг та бүхэн чамлалттай сонсож байгааг ойлгож байна. 5, 6 жил гэдэг маань хэтэрхий урт хугацаа гэдгийг ойлгож байна. Бид аль болох богино хугацаанд бол энэ ажлыг бол шилжих хугацааг хийх гэж байна. Ер нь зүгээр энэ том төслүүд маань өөрөө энэ ашиг олох боломжтой. Тэгээд эдийн засагтай тийм өсөлтийн тэр бүүст авчрах боломжтой төслүүд маань бол ер нь энэ хөгжчихсөн энэ бүх л улс орнуудад тухайн цаг үедээ бол тулгарч байсан юм байна лээ. Тэгээд яг тэр тал дээр манайхаас бол Сангийн

сайдын байгуулсан ажлын хэсэг гараад энэ дээр бол ажиллаад тэгээд бид нар Хөгжлийн банк Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр юуг нь шингээх вэ бүртгэл асуудлаас нь яах вэ гэдэг энэ асуудлыг тэгээд тооцоод явж байгаа бодлого талаасаа. Нэмээд Дэлгэржаргал дарга.

Н.Наранбаатар: 7 номер нэмж хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Үүрийнтуяа гишүүний асуултад нэмж хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Ер нь хүүгийн хувьд бол бид нар зээлийн гадаад зээлүүд дээр хүүгийн зээлийн үйлчилгээний төлбөр дээр 3 асуудал байгаа.

Нэгдүгээрт үндсэн төлбөр, хүүгийн төлбөр тэгээд хөрөнгө баталгаажуулсны шимтгэл гэж байгаа. Тэгэхээр газрын тосны хувьд бол 1.75 хувь. Эрдэнэбүрэнгийн хувьд бол 2 хувь. Тэгэхээр нийт манай яг хөгжлийн түнш байгууллагуудын хувьд бол ихэнх нь яг нэгээс олон талт болон 2 талт гэж 2 явж байгаа. Азийн хөгжлийн банк бол Дэлхийн банк олон талт буюу эдгээр дээр дунджаар дөрөө 4-өөс 5 хувийн хүүтэй.

Хоёр талт буюу Эксим банкууд, Польш, Австри эд нар дээр 1-ээс 2 хувь байгаа. Тэгэхээр бид нар энэ зээлийн үйлчилгээний төлбөр дээр байгаа нэг хөрөнгө баталгаажуулсны шимтгэл буюу энэ зээлийн ашиглалтаа ашиглахгүй байгаа санхүүжилт дээрээ бид нар шимтгэл төлөөд байгаа нь өөрөө зээлийн үйлчилгээний төлбөр буюу төсөв дээр нэмэлт ийм төлбөр үүсэх асуудал байгаа учраас зээлүүдээ хугацаанд нь ашиглаж дуусгах нь бас нэг энэ шимтгэлийг бууруулах зардал хэмнэх боломж байгаа.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? Алтаншагай гишүүн.

Н.Алтаншагай: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Хоттой холбоотой асуудал дээр аяа. Яах вэ энэ нөгөө гэр хорооллыг барилгажуулах энэ ажил маань дахин төлөвлөлт нэртэйгээр 2012, 2013 онд эхэлсэн. Улаанбаатар хотын 5-аас 6 байршил дээр эхлээд бүгд ерөнхийдөө ашиглалтад ороогүй. Дан пийлдээд дууссан. Жишээ нь гэхэд л СХД дээр 3 байршил дээр энэ ажил эхлээд ингээд зогсчихсон. Тэгэхээр энэ дээр хууль эрх зүйн орчныг нь сайжруулаад заавал эхний энэ гарааны энэ төр буюу энэ төр оролцож байж, энэ хот өөрөө оролцож байж эхний ажлуудыг нь явуулах юм байна лээ. Яг энэ утгаараа Сэлбэ дэд төв дээр энэ ажлууд ингээд хийгдээд эхэлсэн.

Цаашдаа бол хотоос өгч байгаа мэдээллээр бол дахиж хот өөрөө ийм ажилд оролцохгүй. Газар чөлөөлөөд мөн сонгон шалгаруулалт хийгээд явна гэсэн ийм мэдээлэлтэй байгаа.

Н.Наранбаатар: 7 номер уу? 6 номерын микрофон.

Т.Даваадалай: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя аа. Засаг даргын 1 дүгээр орлогч Даваадалай.

Сэлбэ дээр нийт 2.2 их наядын төсөл гэсэн тооцоолол гарсан. Үүнээс та түрүүн асууж байна. Гадна тохижилтод 27, гадна инженерийн шугам сүлжээнд 51.2, бусад инженерийн дэд бүтэц дээр 28.3. Цахилгааны дэд станц 17.4. Дулааны станц 20 тэрбум гээд хуваарилагдаад нийт 2.2-оос 1.8-н 4 багцын 8557 айлын орон сууц

бусад зардлууд нь болохоор гадна тохижилт, инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц гэж бусад зардлууд дээр зарцуулагдаад явж байна. Сая Алтаншагай гишүүний хэлдгээр Улаанбаатар хотод өмнө нь 2012 оноос хойш эхлээд хэрэгжиж байсан дахин төлөвлөлтийн төслүүд дээр 2 том үндсэн асуудлаас болоод амжилттай дуусаж чадахгүй байсан.

Нэгдүгээрт газар чөлөөлөлтийг хууль эрх зүй болон бусад асуудлаас чөлөөлж чаддаггүйгээсээ болоод төслүүд амжилтгүй.

Хоёрдугаарт гадна инженерийн дэд шугам сүлжээг уул нь гэрээгээрээ нийслэл хийх үүрэг хүлээдэг боловч тухайн жилийнхээ төсвийн хүрэлцээгүй байдлаас гадна нийтийн шугам сүлжээ дэд бүтцүүдийг хийж чаддаггүйгээсээ болоод ингээд дахин төлөвлөлтийн төслүүд амжилтгүй болоод байсан ийм өнгөрсөн 13 жилийн түүхтэй. Ийм учраас бид нар энэ газар чөлөөлөлт дээр нь нийслэлд дэмжлэг үзүүлье.

Дээрээс нь энэ гадна инженерийн шугам сүлжээн дээр нь анхааръя гэдэг ийм байдалтай Сэлбэ дээр ажиллаж байгаа.

Н.Наранбаатар: 5 номер нэмж хариулъя.

М.Үнэнбат: Гишүүний асуултад нэмж хариулъя.

Энэ гэр хорооллын дахин төлөвлөлтийн журам нь 2014 оноос хойш ингээд өнөөдрийг хүртэл явж байгаа. Өнгөрсөн хугацаанд НЗД-аас сонгон шалгаруулалт яваад нэг ААН шалгаруулаад батламж олгодог. ААН маань ингээд тухайн байрлал дээр байгаа иргэдийн газрыг чөлөөлөх гэрээ байгуулаад мөн тэрийгээ ААН учраас худалдан борлуулаад орсон орлогоороо тэр санхүү төслөө санхүүжүүлнэ гэсэн ийм зарчмаар ингэж яваад тэгээд ингээд ажлаа эхэлдэг. Яваандаа ААН-үүдийн ямар нэгэн байдлаас үүсээд энэ асуудлууд нь ингээд хүндрэл гардаг санхүүгийн бэрхшээлд ордог. Тэгээд тэрэнтэй холбоотойгоор нөгөө газар чөлөөлж өгсөн иргэд маань ч байрандаа орж чаддаггүй. Захиалга өгсөн иргэд маань ч байранд орж чаддаггүй ийм асуудлууд өнгөрсөн 10 хэдэн жил явж байгаа. Нийслэл дээр бол зөндөө энэ асуудлууд байж байгаа.

Ер нь энэ гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой энэ шууд өнөөдөр эхэлчихсэн ажил биш. Энэ 2014 оноос хойш явж байгаа зүйл. Яг энэ гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой өнгөрсөн хугацаанд хэдэн газар чөлөөлж хэдэн ААН-д батламж олгосон юм. Тэрний явц ямар байгаа юм. Өнөөдөр ер нь энэ ямар асуудал тулгараад байдаг талаар дэлгэрэнгүй мэдээллийг гишүүн танд хүргүүлье.

Ер нь зүгээр энэ дээр ганц тулгардаг зүйл нь юу байна вэ гэхээр тухайн батламж авсан ААН маань өөрөө ажлаа гүйцэтгэх боломжгүй боломжгүй болоод ирэхээр туслан гүйцэтгэгч авдаг. Туслан гүйцэтгэгчид нь ажил хийж явж байгаад яг ерөнхий батламж олгосон ажил гүйцэтгэж байгаа хооронд ингээд хоорондоо маргаан үүсдэг. Ингээд иргэдийн эрх ашиг дунд нь хохирч явдаг гэсэн ийм өнгөрсөн хугацаанд гарсан ийм зөрчлүүд байгаад байгаа. Тэгээд энэнтэй холбоотойгоор энэ гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой журмын хэрэгжилтийг ер нь өөрчилье өө. Яг энэ үүсээд байгаа асуудлуудыг шинээр өөр асуудал ороод тэр Хот байгуулалтын хууль болон холбогдох хуульд өөрчлөлт оруулъя гэдэг саналыг БХБ-ын яаманд НЗД-ын зүгээс хүргүүлчихсэн байж байгаа.

Тэгэхээр энэ өнгөрсөн зүйлд гардаг ерөөсөө энэ том тулгардаг зүйл нь санхүүжилтийн л асуудал байгаа. Тэгэхээр бид бүхэн бол энэ Нийслэл дэд бүтэц, энэ төв дээр энэ зорилгын хүрээлэлд оруулсан бондыг яг өөрийнх нь худалдан борлуулалтаар эргэн төлөх ийм график гарчихсан явж байгаа. Бид бүхэн бол яг энэ Бондын болон Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу зөвхөн тэр төсөл арга хэмжээндээ л зарж байгаа. Түүнээс ямар нэгэн өөр асуудал руу оруулахгүй. Тэгэхдээ тэр түрүүний Даваадалай даргын хэлсний дагуу баригдаж байгаа орон сууцыг иргэдэд худалдан борлуулаад орж ирж байгаа мөнгийг нь Сэлбийнхээ өрийг төлнө гэсэн ийм зүйл явж байгаа. Орон нутгийн төсвөөс байдаг юм уу? Энэ ямар нэгэн байдлаар Сэлбийн өрийг дарна гэсэн энэ ойлголт байхгүй байгаа.

Яг графикийн дагуу худалдан борлуулаад эргүүлээд төлнө. 2027 оноос эхний төлөлтийг хийх ёстой байж байгаа. Яг энэ графикийн дагуу бол ажлууд явж байгаа. Түрүүний хэлсэн хойд Сэлбийн бүтээн байгуулалтын ажил эхэлчихсэн барилга угсралтын ажлууд ороод явж байгаа.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? Ирээдүй өв сан дээр. Сангийн яам. Хэдэн номер вэ? 7 номер.

Л.Гантогтох: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя.

Сангийн яам Гантогтох. Ирээдүй өв сангийн үлдэгдэл 2025 оны 12 дугаар сарын байдлаар нийт 1.3 тэрбум ам доллар буюу 4.7 их наяд төгрөг байна. Энэ мөнгө бол Монголбанкн дээр байршаад цаашаагаа Англи, Франц зэрэг Монголбанкны харилцагч төв банкнууд дээр цаашаа байршиж байгаа. Хүүгийн хувьд 3.8-аас 4.4 хувийн хүүтэй байршиж байна аа.

Н.Наранбаатар: Үүрийнтуяа гишүүн нэмэлт нэг минут.

Д.Үүрийнтуяа: Хэд хэдэн саналууд байгаад тодруулах шаардлагатай юмнууд байгаад байна. Санал дээр саналаа хэлье. 2.2 их наядаас нийслэл 1.8 орон сууц бусад нь дэд бүтэц. Тэгээд дэд бүтцээ бид нар өөрсдөө хийгээд төр хийгээд орон сууц барих юмаа тэр хувийн хэвшлээр хийлгэж болдоггүй юм уу. Өнөөдөр 10 жилийн өмнөх нөхцөл байдлыг ярихаас илүү энэ орон сууц барих чадвартай компаниуд чинь харьцангуй хөгжчихлөө шүү дээ. Хувийн хэвшлийн орон сууцын хороолол барьж байгаа компаниуд гаднаас хүн оруулж ирж компани оруулж ирж барьдаггүй байх.

Өнөөдөр Улаанбаатар тэр чигтээ л барилга байна. Яагаад төр оролцоод хамтрахаараа болохгүй болчихоод байгаа юм. Шалгаруулж чадахгүй байгаа юм уу энэ асуудал дээр эргэж харахгүй бол бид нар гаднаас зээл аваад орон сууц хийхэд тухайн айлын нөхцөлийг бид нар зөвшөөрөх ёстой.

Эргээд яах вэ гэхээр гаднын компани орж ирээд л хийнэ дотооддоо авах юм бол дотоодын компаниудаа дэмжих боломж нь гарна. Эдийн засаг дотооддоо эргэлт нь үлдэнэ.

Н.Наранбаатар: Нэг минут нэмж өгье.

Д.Үүрийнтуяа: Газар чөлөөлж байгаа асуудал бол хариуцлагын асуудал байх аа. Тэр хариуцлагагүй байгаа нөхдүүддээ хариуцлагагүй, чадваргүй компани гаргасан нөхдүүдтэйгээ бид нар асуудлаа ярьж чадаж байна уу үгүй юу? Энэ асуудлыг анхаарах ёстой байх гэж бодож байгаа юм. Тэгээд бид нар өнөөдөр бас яах вэ энэ газрын тосны үйлдвэр дээр жишээлбэл энэ хуулийг явуулахын тулд би газрын тосны үйлдвэр болон Эгийн голын тэр эрчим хүчний асуудлууд дээр би дэмжиж байгаа. Би орон сууцын асуудлыг ойлгохгүй байна. Яг үнэнийг хэлэхэд саяын хэлсэн нөхцөлөөр. Тэгэхээр энэ 2 асуудал дээр тэр авсан хүүгийн ашиглагдаагүй хүүгийн зардлын өсөлтийг тэр 10 жилийн хугацаанд хэд гарах юм. Сангийн яам хариулсангүй энийгээ тооцоод гаргачих нь зүйтэй байх. Ямар хэмжээний зардал хэмнэж байгаа юм. Энэ хүүг оруулаад тооцох юм бол өнөөдөр Дэлгэржаргал даргаа 1.2-2 хувь биш шүү. Маш өндөр гарна.

Харьцангуй өндөр гарна. Гэтэл бид нар нөгөө талдаа хэдэн хувиар хадгалж байна. Яг цэвэр зөрүүг нь тооцох хэрэгтэй. Би Ирээдүйн өв санг яагаад асуусан гэхээр энэтэй харьцуулах гэж асуусан юм.

Н.Наранбаатар: Үг хэллээ. Заяабал гишүүн асуулт асууна.

Б.Заяабал: Тэгэхээр Засгийн газрын хийж хэрэгжүүлж байгаа төсөв дээр тавигдчихсан явж байсан ажлууд л даа. Энэ 3 том төсөл бол. Тэгээд энийг Засгийн газар оруулж ирэхгүй гишүүдээр ингээд өргөн бариулж орж ирж байгаа юм байна. Би бол яг энэ нэг төсөв талаасаа энэ бол аягүй буруу жишиг бий болж байна. Маш буруу жишиг бий болж байна. Маш буруу жишиг цаанаа үлдэнэ. Тэгээд энэ гишүүд одоо ингээд л хариуцсан тойрог хийсэн явж байгаа ажлууд дээр санаа зовоод л ингээд л өргөн барьсан байх л даа. Тэгээд өргөн барьж байгаа энэ хууль дээр Засгийн газар саналаа өгсөн байх. Энэ дээр жишээлбэл Засгийн газрын зүгээс тухайлбал Сангийн яам яг ямар санал өгсөн бэ? Сангийн яамны саналыг би сонсмоор байна. Яг энэ гишүүний өргөн барьсан хууль дээр ямар санал өгсөн юм. Уул нь Сангийн яам энийг оруулж ирэх ёстой байсан. Тэгээд өнгөрсөн жил нэг төсвийн дүрэмд өөрчлөлт оруулаад алдагдлаа нэмэх ямар ч боломжгүй ийм төсвийн дүрэм оруулж ирээд батлуулчихсан. Бараг Монголоос өөр оронд тийм төсвийн дүрэм байдаг юм уу үгүй юм уу. Тэгээд ингээд төсвийн дүрэм оруулж ирээд батлуулчихсан.

Өнөөдрийн яригдаж байгаа энэ 3 төслийг аваад үзэх юм бол 1.7, 1, 0.5 гээд ингээд 3.2 их наяд 2 тэрбум доллар буюу 11.5 их наяд төгрөгийн асуудал яригдаад байгаа юм. Төсвийнхөө бүртгэлээрээ бүртгэлийнхээ дүрмээрээ аваад үзэх юм бол энэ зардал дээрээ нэмээд л алдагдлаа нэмээд л явах ёстой. Гэтэл төсвийн дүрэм дээрээ аваачаад ийм миний мэдэж байгаагаар уншиж судалснаар бол ийм сонин дүрэм оруулж ирээд батлуулчихсан тэрнээсээ болоод тэр хязгаартаа багтаж чадахгүй ингээд ийм асуудал үүсгээд байгаа. Үндсэндээ бол дүрмээрээ бол энэ 11.5 их наядаар төсвийн зарлагаа нэмэгдүүлж байгаа ийм л арга байгаа. Цаад тооцооллоороо бол. Монгол Улсын төсвийн орлого өнөөдөр яг урсгал зардлаа хүртэл санхүүжүүлж чадахгүй хэмжээнд хүрчихсэн байгаа. Урсгал зардал дээрээ ер нь буулгах тал дээр ямар шинэчлэл хийж байна аа? Энэ дээр Сангийн яам тодорхой хариулт өгөөч? Зээлийн ашиглалтыг жилдээ 1.5 их наяд гэж байгаа. Яг энэ маягаараа энэ 3 төслөө хасаад цаана нь дахиад зуугаад төсөл байгаа.

Ингээд 1.5 их наядаар явах юм дахиад цаашдаа 8-аас 10 жил хэрэгжүүлэхүйц хэмжээний их төсөл Монголд байгаа батлагдчихсан. Тэгээд өмнө нь бол өнгөрсөн

жил төсөв дээр бид нар энэ удаашралтай байгаа үр дүнгүй болчихсон төслүүдийгээ зогсоо эргэж хар аа, танилцуул гээд тэгсэн. Энэ дээр дорвитой ажил хийгдээгүй, төсвийн удирдлагынхаа нэгжүүдийг менежментийг нь бид нар өөрчилж байна гэсэн ийм л юм яриад л ингээд л өнгөрсөн. Энэ 3 том төслөө авчихаар зэрэг цаана нь зээлийн орон зай дахиад гарна аа. Энэ зээлийнхээ орон зай дээрээ та нар дахиад нэмж зээл авах тухай юм яриа хэлэлцээр хийгдэж байгаа юмнууд байна уу үгүй юу? Энэ дээрээ та нар бас хариулт өгөөч. Би нэг минутыг нь нэмээд аваадах уу?

Н.Наранбаатар: Нэг минут нэмж өгье.

Б.Заяабал: Тэгэхээр Монгол Улс хөгжихийн тулд энэ томоохон төслүүдээ, дэд бүтцийн төслүүдээ ялангуяа явуулахаас өөр арга байхгүй л дээ. Гэхдээ энэ их мөнгөөр Монголд хэрэгтэй юм яг юу хийгдэж байна вэ гэхээр яах вэ үлдэж байгаа хөрөнгө оруулалтууд нь байгаа байх. Гэхдээ энэ бүтээн байгуулалтын ажлыг хийж байгаатай холбоотой Монголын дотоодоос хэчнээн худалдан авалт хийж байгаа юм, хэчнээн бараа материал авч байгаа юм, хэчнээн ажлын байр бий болж байгаа юм. Хичнээн чадвартай ажилчдыг бид нар бэлтгэж авч хоцорч байгаа юм бэ гэдэг дээр тооцоо судалгаа байна уу гэдэг дээр би асуулт асуумаар байна.

Сүүлд нь энэ хууль маань ер нь хэдэн жил хэрэгжих юм бэ? Энэ хугацаагүй л хуулийн төсөл ороод ирчихлээ л дээ. Энэ дээр тодорхой хугацаа зааж хугацаагаар нь шахахгүй бол ингээд үргэлжлээд байдаг. Дахиад л нэг олон жил үргэлжилсэн ийм л хууль болчих гээд байна. Тийм учраас хугацаагаар нь шахмаар байна. 2025 онд энэ 3 төсөв дээр яг хэдийн зарлага гаргах гээд байгаа юм. 2026 онд хэд гаргах гээд байгаа юм гэдэг тооцооллоо хэлж өгөөч.

Н.Наранбаатар: Сангийн яам. 7 дугаар микрофон.

Ж.Дэлгэржаргал: Заяабал гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал.

Хуулийн төсөл дээр Сангийн яам яг энэ гадаад зээлийн ашиглалт дээр тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх хүрээнд зохицуулалт байгаа учраас бүрэн дэмжиж санал албан бичгээр өгсөн. Удаашралтай байгаа төслүүд дээр арга хэмжээ авах асуудал дээр ер нь гадаад зээл дээр явж байгаа бүх төслүүд дээр нэг асуудал нь бол энэ Улсын Их Хурлаас соёрхон баталсан. Нөгөө талдаа хөгжлийн түнш донорууд дээр яг энэ санхүүжилтийг Монгол Улсад энэ хугацаанд олгоно оо гээд ингээд амлалт үүсчихсэн байдаг.

Тэгэхээр бид нар 2025 онд бол яг энэ Улсын Их Хурлын тогтоолуудын хүрээнд нийтдээ бүх төслүүд дээр эрэмбэлээд 178 тэрбумын зөвлөх үйлчилгээ, сургалт судалгааны ажлууд, зарим шаардлагагүй худалдан авалтуудыг хэмнэх ийм зохицуулалтуудыг доноруудтайгаа хийсэн. Тэгээд энэ 178 тэрбумыг буцаагаад газрын тос Эрдэнэбүрэнгийн ашиглалт дээр тавьсан. 2025 онд 1.5 их наядаас газрын тос дээр 405 тэрбумын ашиглалт гарсан. Эрдэнэбүрэн дээр 272 тэрбум гарсан. 2026 оны гадаад зээлийн ашиглалт 1.5 байхаар бид нар өргөн барьсан боловч Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн явцад бол 307 тэрбумаар бууруулаад 1.2 байгаа.

Тэгэхээр энэ 1.2-оос одоогийн энэ батлагдсан хүрээнд яг газрын тос дээр нэг 2 зуугаад тэрбумыг Эрдэнэбүрэн дээр нэг 90-ээд тэрбумыг олгох ийм тооцоолол

байгаа. Тэгэхээр энэ хуулийн төслийн хүрээнд энэ 2 хуулийн төсөл хэрвээ батлагдвал газрын тос дээр 1.7 их наяд гарна. Эрдэнэбүрэн дээр 2 зуугаад тэрбум гарна гэсэн тооцоолол байгаа. Тэгэхээр энэ 2 төслийн хувьд одоо яг гадаад зээлийн ашиглагдаагүй нийт 14.7 их наядаас зөвхөн энэ 2 төслийн ашиглалт бол 5.6 гэхээр цаана нь 9.1 их наядын ашиглагдаагүй үлдэгдэл бусад төслүүд дээр үлдэнэ. Тэгэхээр энэ төслүүдийн яг ингээд нийт хугацааг нь авах юм бол хамгийн цаад талын хугацаа нь 2029 онд дуусах буюу 9.1 их их наядыг бид нар яг энэ хугацаанд яг төсвийнхөө энэ зардлын хязгаарт яваад ашиглах ийм тооцоололтой байгаа. Нийт төслүүдийн хувьд ингээд бүтцээр нь аваад үзэх юм бол эрчим хүчний салбар дээр маш олон хамгийн их төслүүд байгаа.

Хоёрт нь Улаанбаатар хотын суурь дэд бүтэц байгаа. Тухайлбал Улаанбаатар хотын дэд төвүүд орон сууцын төслүүд гээд өмнө эхлүүлчихсэн байсан төслүүд явж байгаа. Нэмж энэ хуулийн хүрээнд энэ 2 төслийн ашиглалтыг ингээд явахаар цаана нь үлдэж байгаа бид нар зөвхөн 2026 оны хүрээнд 1.2 дотор бусад төслүүд явна гэхэд бол энэ дээр шинэ төслүүд бол зээлийн хэлэлцээр нь соёрхон батлахаар явж байгаа Улсын Их Хурал дээр 2 төсөл явж байгаа.

Нэгдүгээрт Европын сэргээн босголт хөгжлийн банкны Зүрх судасны үндэсний төв,

Хоёрт нь бол Азийн хөгжлийн банкны санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр байгаа. Энэ дээр боловсрол онцгой эрүүл мэндийн салбар байгаа. Тэгэхээр бид нар энэ 2 төслийг яг энэ хуулиар зээлээ ашиглаад явахаар бусад төслүүдээ бол яг энэ хугацаанд нь одоо явж байгаа соёрхон батлах төслүүдээ оруулаад хугацаанд нь хэрэгжүүлэх боломжтой. Гэхдээ нөгөө талдаа яг одоо энэ жил хэмнэсэн 178 шиг 2026 он дээр ч гэсэн бид нар бүх төслүүд дээр энэ хэмнэлтүүдийг хийж байгаа. Шаардлагагүй зөвлөх үйлчилгээг хойшлуулах, дахин хуваарилаад илүү дэд бүтэц бүтээн байгуулалтын ажилд зарцуулах. Үүнтэй холбогдуулаад энэ нэгдсэн төслийн нэгжийн зохион байгуулалтад ороод урсгал зардал талдаа хамгийн багадаа 11 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан. Төслийн нэгжүүд дээр одоогоор нийтдээ улсын хэмжээнд 474 хүн ажилладаг бол нэгдсэн төслийн зохион байгуулалтад орсноор 203 хүн ажиллах ийм зохицуулалтуудыг хийж байгаа.

Дээрээс нь төслийн нэгжүүдтэй холбоотой тусдаа байр түрээслээд явах асуудлыг зогсоогоод 1 сарын 1-ээс яамдууд дээрээ байршаад энэ түрээсийн зардал гэх мэт ийм урсгал зардлуудыг хэмнэх энэ эрэмбэ бас ингээд хийгдээд явж байгаа.

Н.Наранбаатар: Нэмэлт хариулт. Санжаадорж хаачсан? Санжаадорж. Хуулийн хугацаа асуусан 5 номерын микрофон хариулья.

М.Үнэнбат: Гишүүний асуултад хариулья. Хуулийн хугацааны тухайд хугацаа тавиагүй байж байгаа. Яагаад гэхээр энэ хууль маань зөвхөн хууль дотор байгаа 3 төслийн хүрээнд хэрэг яригдаж байгаа. Энэ 3 төсөл хэрэгжиж дууссанаар энэ хууль бол цаашаа хэрэгжээд явах шаардлагагүй болно нэг талаасаа. Нөгөө талаасаа бол энэ нөгөө гүйцэтгэлээр нь санхүүжилт хийж явах ёстой болохоор магадгүй 5 гэдэг юм уу, 2030 он хүртэл гэдэг юм уу 2035 он хүртэл энэ хууль хэрэгжинэ гээд тавьчихвал нөгөө талдаа нөгөө хэрэгжиж дуусаагүй асуудал гаргах юм бол энийг яах вэ гэдэг юм руу орох учраас энэ хууль зөвхөн энэ 3 төсөл хэзээ хэрэгжиж дуусна тэгээд л энэ зүгээр цаашаагаа үйлчилнэ. Үйлчлэх нөгөө эрх зүйн үндэслэлгүй болох учраас хугацаа тавиагүй байж байгаа. Тэгэхээр бол гишүүд нөгөө хэлэлцүүлгийн

явцад хугацаа шаардлагатай гэвэл санал гаргаад тавих боломж нь байгаа гэж үзэж байгаа.

Н.Наранбаатар: Санжаадорж дарга нэмэлт хариулт. Хуулийн хугацаа хүчинтэй байх хугацаа хэзээ дуусах юм гэсэн. Нийтдээ энэ 3 төсөл дээр хэдий хэмжээний үлдэгдэл байгаа юм ашиглах гээд байгаа үлдэгдэл.

М.Санжаадорж: Гишүүдээс гарч байгаа саналууд бол тэгээд ерөнхийдөө бол жишээ нь Хөгжлийн банкаа та нар яагаад ашиглаагүй юм бэ гэдэг асуудал.

Хоёр дахь нь бол хуулийн хугацаатай байх ёстой юм биш үү өшөө шахах Засгийн газарт үүрэгжүүлэх асуудал байх юм биш үү? Гуравт нь бол үр ашгийг сайжруулах асуудал байх юм биш үү гэдэг ийм нийтлэг ажлууд гарч байна. Тэгээд дээр нь бол сая сүүлд Заяабал гишүүн асууж байна. Хичнээн орон тоо бий болгох юм бэ энэ эдийн засагт яаж нөлөөлөх юм бэ гэдэг ийм зүйл ярьж байна. Тэгэхээр хуультай холбоотойгоор бол Улсын Их Хурлаас бол бүрэн эрхийнхээ хүрээнд бол тогтоол гараад энийг бол ийм хугацаанд үр дүн нь ингэсэн байх ёстой. Одоогийн хуулийн төсөл дээр бол гүйцэтгэл дээр тайлагнах асуудал байгаа.

Тэгэхлээр магадгүй хагас жил бүтэн жилээр улирлаар ч байдаг юм уу тайлагнах асуудлыг чиглэл өгөхөд бол нээлттэй гэж бол бид бодож байна. Одоо бол нөгөө газрын тосны үйлдвэрийнх нь болон Эрдэнэбүрэнгийн хувьд бол цаанаасаа нөгөө гэрээнийх нь дагуу хийчихсэн бид нарын хувьд бол хугацаа байгаа. Энэ хугацаагаараа л хязгаарлагдах ёстой гэж бид үзэж байна. Тэгэхдээ энэ 3 төсөл маань гурвуулаа нөгөө өөр өөр хугацаатай учраас яаж явах вэ гэхлээр хууль дээр бол яг дэмий болоод зүгээр чиглэл өгч байгаа тогтоол санаачлаад явбал байж болох болов уу гэсэн тийм саналтай байна.

Н.Наранбаатар: Эхлээд 7 номер нэмээд хариулчих. Дараа нь Заяабал гишүүн.

Ж.Дэлгэржаргал: Ажлын байр дээр нэ ж тодруулж хэлье гэж бодож байна. Гадаад зээл тусламж дээр манай Сангийн яамнаас хийсэн судалгаагаар ер нь яг зээлийн нэг төсөл боловч дотроо төслүүдээрээ задраад маш олон ийм гэрээнүүд хийгддэг. Тэгээд 2024, 2025 оны судалгаагаар 1500 ААН-тэй гэрээ байгуулж 20 мянга гаруй ажлын байрыг дотооддоо хадгалсан байна гэж судалгаа гарсан. Хуулийн хугацааны хувьд бол яг энэ Улсын Их Хурлаар соёрхон баталсан хугацаа буюу газрын тос 2028 он, Эрдэнэбүрэнгийн УЦС 2030 он байгаа. Тэгэхээр яг энэ хугацаанд энэ хуулийн үйлчлэл дуусна гэж үзэж байгаа.

Н.Наранбаатар: Заяабал гишүүн нэмж асууя.

Б.Заяабал: Тэгээд би энэ дээр дахиад тодруулаад нэг юм асуучихъя даа. Ер нь тэгээд манай сүүлийн үеийн төсвүүдийг хараад байхад ер нь зээлээр л ийм томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг хийдэг ийм л болж байна л даа. Тэгээд орж ирж байгаа төсвийн орлого нь урсгал төсөв цалин нь нөгөө нэг үйл ажиллагаандаа төрийнхөө үйл ажиллагаандаа зарцуулаад дуусдаг ийм л арга хэлбэр лүү орлоо. Төсвийн тэлэлт асар их хэмжээгээр нэмэгдсэн, зардал асар их хэмжээгээр өссөн. Ингээд зээлээр дулдуйдсан ийм л төсвийг бид нар явуулж ирж байна л даа. Тэгээд энэ дээрээ Сангийн яам ер нь ямар шинэчлэл хийх гэж байгаа

юм бэ? Урсгал зардал талдаа гэж асуусан. Энэ дээр Санжаа дарга нэмээд хэлээд өгөөч.

Хоёрдугаарт нь яг ийм аргаар төсвөөсөө гаргаад санхүүжүүлээд зээлийнхээ хөрөнгүүдийг санхүүжүүлээд явдаг ер нь ямар орны туршлага байна аа? Энэ жишиг болоод явчихаар тийм орон байхгүй байх л гэж би бодож байна. Энэ дээр нэг хариулж өгөөч. Тэгээд зээлийн энэ нэгжийнх нь ирчихсэн байгаа юм байна. Энэ зээл ямархуу хэмжээтэй энэ ажлууд нь явж байгаа юм бэ? Газрын тос, Эрдэнэбүрэн, Улаанбаатар хотын энэ.

Н.Наранбаатар: Сангийн яам, индрийн микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Урсгал зардалтай холбоотойгоор бол бид нар бол зардал бууруулах чиглэлээр бол ер нь хавар бол Улсын Их Хурал дээр бол ажлын хэсэг дээр бол танилцуулгууд 4, 5 чиглэлээр танилцуулсан байгаа. Хууль тогтоомжийн хүрээнд ямар асуудлууд байна, статистик, хүн ам зүйн өөрчлөлтийн хувьд ямар асуудлууд байна гээд. Тэгээд бүх талаас нь бол ярилцсан байгаа. Эцсийн сүүлдээ бол юун дээр очсон гэхээр яг хууль болгоноор нэг болгоноор нь хөндөхөөр энэ өөрөө бол бас нэлээд ажил авах мөн эрсдэлтэй ийм зүйл байгаад байна гэдэг зүйл явсан. Ийм учраас бол ДНБ-тэй харьцуулж явах нь зүйтэй байна гэдэг зүйлийг бол гаргаж ирж ярьж байгаа. Жишээ нь номинал дүнгээрээ бол зарлага бол нэмэгдээд явж байгаа. Гэхдээ энэ нь ДНБ буюу нийт эдийн засгийн потенциалынхаа хувьд татан төвлөрүүлж байгаа орлого маань хэр их байна. Үүнийгээ дахин хуваарилж байгаа орлого маань хэр их байна. Мөн зээлийн хэмжээ маань хэр их байна гэдгийг.

Н.Наранбаатар: Зээлийн нэгж Чойжилсүрэн сайдаас эхлээд тэгээд Газрын тос, нийслэл гээд явчихъя. Та мэдээлэл өгөх үү? Эрдэнэбүрэнгийн ажил ямар явцтай байгаа юм? Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Гишүүдийнхээ амрыг эрье. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төсөл нэлээн гацаатай явсан. 2024 оны эхэн, 2023 оны төгсгөлөөр. Энэ гацаа гараад ажил хэвийн үргэлжилж байгаа. 2029 оны 2 дугаар улиралд ашиглалтад оруулахаар ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Нийтдээ 266 сая доллароор бүтэх төслийг нь 95 хувь нь Эксим банкнаас санхүүжүүлж байгаа. 5 хувийг нь Монголын Засгийн газар санхүүжүүлсэн байдалтай. Төсөл дээр ямар нэгэн гацаа саад байхгүй ажил хэвийн явж байгаа.

Н.Наранбаатар: Газрын тос 8 номерын микрофон.

Д.Алтанцэцэг: Сайн байцгаана уу? Алтаншагай гишүүн тэргүүтэй Улсын Их Хурлын гишүүд манай газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөлд нэн чухал энэ хуулийг санаачлаад явж байгаад төсөл хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс гүн талархал илэрхийлье ээ.

Мөн Төсвийн байнгын хорооны гишүүдэд мөн баярласнаа илэрхийлж байна аа. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл амжилттай хэрэгжиж байгаа. Үйлдвэрийн төсөл маань 4 багц ажлаас бүрддэг. Эхний багц ажил 100 хувь дуусаад бид нар барилга байгууламжууд тэгээд байнгын ашиглалтад хүлээж авсан. 2, 3 дугаар багц ажлын инженерчлэлийн ажил 90 хувьтай ер нь удахгүй дуусна. Энэ

инженерчлэлийн ажил 30 хувиас эхэлж тоног төхөөрөмжүүдийн захиалга хийгдэж эхэлдэг. Ингээд Энэтхэгийн ер нь гол тоног төхөөрөмжүүд Энэтхэгт үйлдвэрлэгдэж байгаа. Гэхдээ манайд Герман, Франц, АНУ, Малайз энэ тэр гэсэн улсад үйлдвэрлэгдэж байгаа байгууламжууд бий.

Н.Наранбаатар: Нийслэл эхлээд нийслэл хариулчихъя. Хэдэн номер байна? 6 номерын микрофон.

Т.Даваадалай: Гишүүний асуултад хариулъя аа. Засаг даргын 1 дүгээр орлогч Даваадалай Сэлбийн түрүүн танилцуулж байсан 12 инженерийн багцын гүйцэтгэл энэ жил 15 хувь, 302 тэрбумын гүйцэтгэл гараад дуусахаар байж байгаа. Бид нар 2026 онд инженерингийн энэ 12 багцын ажлын гүйцэтгэлийг 65 хувьд хүргэх 850 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарахаар тооцоологдоод 2027 ондоо ажлыг бүрэн дуусгана. Нийгмийн дэд бүтцүүдийн сонгон шалгаруулалтыг 1 сарын эхээр хувийн хэвшлүүдийн дунд уралдааныг зарлахаар ажлын хэсэг байгуулагдаад бэлтгэл хангагдаад дууссан явцтай явж байна аа. Баярлалаа.

Н.Наранбаатар: Алтанхуяг гишүүн асуулт асууна.

Н.Алтанхуяг: Надаа нийслэлээс нэг асуулт байна. Нийслэл ер нь хэчнээн хэмжээний бонд босгоод юу юунд зарцуулчихаад байгаа юм, үлдэгдэл байгаа юм уу? Юунд зарцуулахын үлдэгдэл байвал тэр цахилгаан станц руу бас бондынхоо мөнгийг өгсөн гээд байдаг юм. Хэдийг өгсөн юм.

Хоёрдугаарт, Наранбаатар дарга энэ ингэж явахгүй л дээ. Сая дөнгөж бид нар төсөв батлаад явуулсан. Одоо төсвийн бүх үзүүлэлтийг эвдэх ийм зүйл. Энэ 2025 оны 5 сарын 7-ны өдөртэй огноотой Засгийн газрын хурал нь 6 сарын 4-нд болоод хавар шүү дээ дэмжээгүй. Одоо би ингээд харахад энэ ер нь төсвийн том тодотгол маягийн юм явж байна. Тэгээд ингээд 21 гишүүн. Гишүүдийн буруу байхгүй л байх л даа. Манай гишүүд сайхан юм санаад л тэгээд хэрэгт ордог юм шүү дээ дараа нь. Хориод гишүүнээр гар хөлийн үсэг зуруулаад гишүүнээр бариулж байгаа их буруу. Энэ дээр бол би 2 горимын санал хэлмээр байна 1 дүгээрт Ерөнхий сайдаа дуудмаар байна, Сангийн сайдаа дуудмаар байна. Тэр нийслэлийн даргаа дуудмаар байна. Эсвэл та нар түрүүн Батжаргал гишүүн яриад тэгээд Батжаргал гишүүн ч биш дарга болчихсон шүү дээ бүлгийн дарга болчихсон. Бүлэг дээрээ нэг яриач. Энэ их ноцтой шүү. Их Хурал ингэж ажил хийх юм бол энэ хулгай хийж байгаа л хэлбэрийн юм болж байна. Хуулийн нэр нь бол гадаадын зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай биш гэж байгаа юм. Угтаа бол гадаадын зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх, үр ашгийг нь бол нэмэгдүүлэх тухай ойлголт байхгүй. Төсвийн маш олон заалтууд бол зөрчилдөж байна. Та нар тэнд Засгийн газрын 6 сарын 4-ний өдрийн хуралдааны тэмдэглэл байна уу эрхэм гишүүдээ энийг уншаач.

Тэгээд энэнээс өөрөөр ингээд сүүлд нь өөрчилчихсөн юм бол тэгвэл тэр цаас чинь хаана байгаа юм. Энэ Сангийн яам бид нар дэмжээд байна гэж байгаа юм. Та нар энэ Засгийн газрын хурал дээр дэмжээгүй л байна л даа. Манай ийм олон үзүүлэлт ингээд эвдэрнэ гээд хэлчихсэн.

Тэгэхээр 1 арга хайвал яасан юм. Би бол өнөөдөр энэ энэ байдлаараа үргэлжилбэл маш ноцтой үр дагаварт хүргэнэ. Энэ өмнөх тэрний өмнөх 2020 оны хаана хэзээ ч билээ дээ нэг төсөв батлаад төсөв батлагдангуут хойноос нь жорлон барина, 100 тэрбумыг Эрдэнэт үйлдвэрээс гаргана гээд л ингээд л төсвөө эвдэж

байсан юм. Одоо бол бүр хэдэн 100 тэрбумаар нь эвдэх ийм л үр дагавар луу очоод байгаа юм л даа. Та нар маань тэгээд ухаантай улсууд байна. Жаахан яриад зөв шийдэл хиймээр байна хууль зөрчиж болохгүй. Ер нь Алтаншагай ийм төсөв мөнгө гадаадын зээлээр Их Хурлын гишүүд ч гэсэн хуулийн төсөл өргөн барих эрхгүй байх. Энэ дээр үед хаасан л юм л даа би сайн мэдэхгүй байна. Ийм ингээд нэг жоохон улс орноо бодоод энэ хүн ардынхаа ахуй амьжиргааг бодоод энэ төслийг чинь явуулахгүй.

Н.Наранбаатар: Нэг минут нэмье.

Хоёр дахь нь энэ хэнээс асууж байна? Газрын тос. Газрын тосны үйлдвэр барихгүй гэж ер нь ямар дурак нь хэзээ ярьсан юм. Хэзээ ч яриагүй. Хурдан бариач л гэж шаардсан шүү дээ. Тэгээд яагаад босдоггүй юм наадах чинь. Яг Энэтхэгээсээ нөгөө Энэтхэг чинь зээлээ өгөөд буцааж төлөх хугацаа нь болчихоод зээлээ сунгаа биз дээ. Энэ чинь цэвэр манай Засгийн газар гэдэг юм уу хариуцаж байгаа хүмүүсийн дэндүү хариуцлагагүй, дэндүү сэтгэлгүй, дэндүү нэг ийм л хоноцын сэтгэлгээгээр л ханддаг хүмүүсийн юм гэж ийм 2 асуулттай байна. Би Нийслэл юу 2-оос тэгээд Наранбаатар дарга би танд бүүр онцлон анхааруулж байна шүү. Хэрвээ энэ ингээд цаашаа явах юм бол энэ том асуудал үүснэ шүү. Ингэж бол хуулийг хийж болохгүй. Ингэж гадаадын зээлийг шууд бид нар гар өргөн нэмэгдүүлээд явж болохгүй. Тэр Сангийн яам заавал оролцоно. Засгийн газар заавал оролцоно.

Н.Наранбаатар: Эхлээд нийслэл 6 номер хариулъя.

Т.Даваадалай: Алтанхуяг гишүүний асуултад хариулъя аа. Засаг даргын 1 дүгээр орлогч Даваадалай. Нийслэлээс ямар ямар бондууд гарсан юу юунд зарцуулагдсан үлдэгдэл байна уу гэсэн асуулт асуусан. 2024 онд 3 бондын эрх авсан. 201, 264, 265 дугаар тогтоолоор 3 бондынх. Эхнийх нь 2024 оны 201 дүгээр тогтоолоор 500 тэрбум төгрөгийг нь дотоод бонд босгож Бөөрөлжүүтийн цахилгаан станцад 300 тэрбумыг дамжуулан зээлээр хөрөнгө оруулалтын менежментийн корпорацаар, 200 тэрбумыг Улаанбаатар хотын зам засвар бүтээн байгуулалтуудын ажилд ашигласан. Энэ зээлийг дамжуулан зээлээд эргэн төлөлтүүд нь хийгдээд ингээд явж байгаа. 2025 оны 6 сарын 25-нд эргэн төлөөд дуусчихсан байна. 2024 онд дараагийн босгосон 500 сая ам.долларын Сэлбийн бондоос 302 тийм тэрбумын гүйцэтгэл энэ жил гарчихсан. Бусдууд нь бол дотоод системийн банкнуудад ингээд хадгалагдаад үлдэгдэл хэлбэрээр байж байгаа. Түрүүн ярьсан 2026 онд бол гүйцэтгэл 65 хувьд хүргэж бид нар 850 тэрбумыг гаргана гэсэн ийм тооцоололтой ажиллаж байна аа. 87.2 сая ам.долларын бондыг 2024 оны 12 сарын 17-ны өдөр гаргаж батарей хуримтлуурын станцаар Улаанбаатар хотын 50мвт-ын хүчин чадалтай 200мвт цаг буюу оргил цагийг 4 цаг дэмжих батарей хуримтлуурын яг төслийг санхүүжүүлж төсөл амжилттай дуусаж эргэн төлөлт гүйцэтгэж байгаа. Улаанбаатар Энержи гэдэг компани борлуулалтын орлого бол 23 тэрбум хүрчихсэн ингээд явж байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Газрын тос боловсруулах үйлдвэр. 7 номер уу? 8 номерын микрофон.

Д.Алтанцэцэг: Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл амжилттай хэрэгжиж байгаа. 4 багц ажлын хүрээнд гээд түрүүн яриад тасарсан. 4 дүгээр багц ажлын гэрээг 2025 оны 2 сарын 6-нд хийсэн. Энэ гэрээний инженерчлэл

худалдан авалт барилга угсралтын гэрээний хугацаа 36 сар. Ингээд инженерчлэл буюу нарийвчилсан зураг төсөл 3 хэмжээст модулийн ажлаар эхэлдэг. Ингээд үйлдвэрийн 2, 3 дугаар багц ажил ер нь түрүүлж дуусах шинжтэй. Яагаад гэвэл 2 жилийн өмнө гэрээг нь байгуулсан учраас. Магадгүй 4 дүгээр багц ажлын гэрээг хийхэд өнгөрсөн жил Энэтхэгийн Засгийн газрын нэмэлт санхүүжилт бол 2024 оны сүүлчээр шийдэгдсэн. Ингээд Улсын Их Хурлаар соёрхон батлагдаад бид нар түүний дараа 4 дүгээр багц ажлынхаа гэрээг байгуулсан. Төсөл бол Ковид цар тахалтай холбоотойгоор нэг жил орчим ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад хугацаа алдсан байж магад.

Түүнээс биш 2019 онд инженерчлэлийн ажил эхэлсэн цагаас хойш тасралтгүй ингээд хэрэгжээд явж байгаа. Баярлалаа тэгье.

Н.Наранбаатар: Алтанхуяг гишүүн тодруулъя.

Н.Алтанхуяг: Та иргэдэд би их олон удаа таныг сонслоо. Ингээд л амжилттай хэрэгжиж байгаа юм бол босчих байсан байхгүй юу. Та нэг ийм ойлголт хэлээч. Анх хэдэн онд эхэллээ хэдэн онд ашиглалтад орно гэлээ. Тэгээд дахиад тэр маань юу болж хойшиллоо. Та энэ дээр их тодорхой юм хэл л дээ. Худлаа хэлээд байх юм. Одоо үнэхээр энэ газрын тосны үйлдвэр Монголд нэлээн сүрхий ач холбогдолтой эд. Тэгэхдээ дараа нь яаж ажиллах юм би мэдэхгүй байгаа зүгээр. Тэр нь дүүрч. Тэгээд хэзээ ашиглалтад орох юм? Өмнө нь яагаад орох байсан хугацаандаа ороогүй юм? Та тэн дээр л олон нийтэд хэл.

Н.Наранбаатар: Хариулъя. 8 дугаар микрофон. Албан тушаал нэрээ хэлнэ шүү.

Д.Алтанцэцэг: Монгол газрын тос боловсруулах үйлдвэр компанийн гүйцэтгэх захирал Алтанцэцэг. Би худлаа мэдээлэл өгөөгүй. Энэ төсөл бол 2 улсын Засгийн газрын хооронд хэрэгжиж байгаа нэмэлт зээлийн санхүүжилт бол шаардлагатай болсон. Энд 2 улсын Засгийн газар хичээж ажиллаад нэг жил 8 сарын дараа бол энэ шийдвэр гарсан. Тэгэхээр бүх багц ажлуудын ажил гүйцэтгэгдэж дуусаж байж үйлдвэр ашиглалтад орох юм аа. Тэгэхээр анх бол ТЭЗҮ-ийг 2019 онд эцсийн байдлаар батлаад дуусахад бол 2025 он гэж ярьж байсан нь үнэн. Гэхдээ энэ цар тахал гадаад, дотоод нөхцөл байдал гээд дээрээс нь зээлийн санхүүжилт гээд маш олон төсөл хэрэгжүүлэгчээс хамаарахгүйгээр ийм мэдээж хойшлогдох шалтгаан гарсан. Гэхдээ манай энэ газрын тос боловсруулах үйлдвэр бол та бүхэнд гэж хэлэхэд дэлхий дээр ингээд бүгдийг нь шинээр эхлээд бариад бүх дэд бүтэц байна цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй байна. Усны шугам хоолойг нь татаад ингээд хийж байгаа гэдгийг.

Н.Наранбаатар: Гүйцээе. Нэг минут өгье.

Д.Алтанцэцэг: Тэгээд 2028 онд ашиглалтад оруулахаар ярьж байна. Тээвэр тээврийн ажил бусад газартай харьцуулшгүй хүнд. Бид нар Энэтхэг улсаас авчирч байгаа ихэнх тоног төхөөрөмжүүдээ. Дээрээс нь манай улсад барилгын улирал маш богино байна. Ерөнхийдөө ажиллаж чадаж байгаа сар 7-8 сарын хооронд ажиллаж болж байна. Гэхдээ яах вэ энэ удаад бид нар өвөл бол 7 зуугаад Энэтхэг ажилчин тэнчээ үргэлжлүүлээд 24 цагаар ажиллаж байгаа дотор хийж болох ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа. Баярлалаа.

Н.Наранбаатар: Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Энэ хуулийн төслийг өргөн барилдсан гишүүдийн нэг байгаа юм аа. Энэ хуулийн төсөл нь стратегийн ач холбогдолтой. Богино хугацаанд зээлээ эргэн төлөх чадвартай үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн гэсэн ийм шалгуураар энэ 3 төслийг оруулж ирсэн, ийм хуулийн төсөл. Энэ дотроос миний нэлээд хамгийн сайн мэдэж байгаа нь Дорноговийн Алтанширээгийн Газрын тос боловсруулах үйлдвэр байгаа юм. Энэ үйлдвэр дээр бол Байнгын хороон дээр ажлын хэсэг би ахлаад нэг удаа хугацаагаа сунгаад нийтдээ 2 чуулганы хугацаанд ажиллалаа манай гишүүд. Бид нар санал, дүгнэлтээ гаргасан. Энэ хугацаанд Монгол Улс шатахууны хомсдолд орлоо асуудал нэлээн гарсан. Гэхдээ бид энэ ажлын хэсгийн үүднээс нэг ч удаа улс төржөөгүй. Яагаад гэхээр энэ газрын тосны үйлдвэр 2025 онд ашиглалтад орох ёстой байсан зээл төлөх хугацаа болсон буцаагаад сунгасан. Яасан бэ гэдэг асуудал дээр л бид нар шалгалт хийсэн юм. Энэ байна шүү дээ 2, 3 ч удаа зээлийг соёрхон баталсан. Дандаа нэмэгдсэн. 2016 онд анх 1 тэрбум доллар байсан. 2019 онд 1.2 тэрбум доллар болсон. Өнгөрсөн жил бид нар 1.7 болгож Улсын Их Хурал соёрхон баталсан байхгүй юу.

Тэр соёрхон батлахын өмнө яг манай ажлын хэсгээс Байнгын хорооноос Засгийн газарт чиглэл өгсөн. 2028 оны 2 дугаар улиралд багтааж ашиглалтад оруул гэж. Орохгүй нөгөө л нэг олон чиглэлүүдийн нэг болно. Яагаад ордоггүй вэ гэвэл маш олон хүчин зүйл байгаа. Тэрнээс хамгийн гол нь одоо өнөөдрийн бид нарын ярьж байгаа юм энэ байхгүй юу. Жишээ нь Газрын тосны үйлдвэрээс 2026, 2027 онд 500, 500 сая долларын санхүүжилтийг авч бид ажлаа хийе гэхэд бид нар өнөөдөр 207 тэрбум төгрөгийг л 2026 оны тавьж өгсөн юм. Илүү тавьж өгөх боломжгүй. Тэгчхээд 2028 онд оруул гэж бид нар ингээд чиглэл өгчхөөд сууж байгаа байхгүй юу. Энэ худлаа байхгүй юу. Надад энэ худлаа байдал ерөөсөө тийм таалагдахгүй. Энэ байж болохгүй үйлдэл. Бид нар энэ эрх зүйн болоод эдийн засгийн боломжийг нь бид нар нээж өгч байж дараа нь энэ үйлдвэрийг ашиглалтад оруул гэдгээ бид нар тавих ёстой юм л даа. Та нар бод доо. 2016 оноос хойшоо 1 тэрбумаар барих байсан үйлдвэр одоо ингээд 1.7 тэрбум болчихсон. Энэ дээр өчнөөн дутагдал бий. Одоо газрын тосны хайгуулыг нэмж хийх ёстой бүүр тусдаа тийм агентлаг байх ёстой гээд бид нар тийм олон санал, дүгнэлт хийсэн. Энэ хуулийг дэмжиж энэ хуулийг өргөн барилцаж байгаа нь ийм учиртай. Бид нар өнөөдөр жилд 207 тэрбум төгрөг тавиад байх юм бол энэ газрын тосны үйлдвэр 15 жилийн дараа юм уу эсвэл 20 жилийн дараа ашиглалтад орно оо ийм дүр зураг харагдаад байгаа юм.

Тэгэхээр эрхэм гишүүд яг энэ нөхцөл байдлаа хараад өгөөч.

Н.Наранбаатар: Нэмж нэг минут өгье.

Л.Мөнхбаясгалан: Холбогдох хүмүүс нь хэлээд өгөөч. Яг өнөөдрийн байгаа байдлаараа явах юм бол жилдээ 207 тэрбум төгрөгөө газрын тосны үйлдвэр дээр тавих юм бол хэдэн жилийн дараа бид газрын тосны үйлдвэртэй болох вэ? Энийг надаа хэлээд өгөөч. Үйлдвэр баригдахгүй байгаа шалтгаан нэг нь энэ мөн үү? Сангийн яам, Газрын тосны үйлдвэр 2-оос асууя.

Н.Наранбаатар: Чуулганы нэгдсэн хуралдаанд гишүүд орж санал хураалтад оролцох зайлшгүй шаардлагатай байгаа учраас Байнгын хорооны хурлыг түр завсарлуулаад гишүүд саналаа өгчхөөд орж ирээд тэгээд хариултаар үргэлжлээд явъя. Түр завсарлалаа.

Байнгын хорооны хурлаа үргэлжлүүлэе хамгийн сүүлд Мөнхбаясгалан гишүүн асуулт асуусан. Хэн хариулах вэ? Сангийн яам эхэлж хариулна дараа нь газрын тосны үйлдвэр хариулна. Сангийн яам 7 дугаар микрофон байна уу? Хэн хэн хариулах вэ? 7.

Ж.Дэлгэржаргал: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Төслийн яг нийт зээлийн эх үүсвэрийн хувьд бол анх Энэтхэгийн Засгийн газартай яг ерөнхий хэлэлцээр буюу 1 тэрбум ам.долларын ийм зээлийн санхүүжилтийг олгож болох асуудал анх батлагдсан. Тэгээд яг энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ бүрэн хийгдээд тэрний дараа яг энэ үйлдвэр өөрөө 1.2 тэрбум ам.доллар болох тооцооллын дагуу 1.2 болсон. Сүүлд яг энэ 4, 5 жилийн хугацаанд нийт 1.2 тэрбум ам.долларын хувьд яг үнийн өсөлт болон зарим нэмэлт санхүүжилттэй холбоотой ЕРС 4-тэй холбоотой ингээд 435 сая ам.доллар батлагдаад одоо яг 1.6 тэрбум ам.доллар буюу ойролцоогоор 1 их наяд байгаа. Тэгээд нийт өсөлт бол 34 хувь.

Н.Наранбаатар: 7 номер нэмж хариулна.

Д.Алтанцэцэг: Улсын Их Хурлаар Соёрхон баталсан хэлэлцээрийн хугацаа 2028 он. Яг төсөл 2028 онд дуусах хугацаатай. Яг төсвийн зардлын хязгаарт ороод энэ байдлаараа зээлийн ашиглалт гарах юм бол 10-аас 15 жил болох эрсдэлтэй гэж тооцоолол гарсан.

Н.Наранбаатар: Газрын тос боловсруулах үйлдвэр. 8 номер.

Д.Алтанцэцэг: Алтанцэцэг Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр компанийн гүйцэтгэх захирал. Дэлгэржаргал дарга сая ерөнхийдөө хэлчихлээ. Гэхдээ нэг 2 зүйлийг нэмээд бушуухан хэлчихье. Энэ зээл олгож байгаа Энэтхэгийн Эксим банк Гадаад хэргийн яамнаас бид нарт 2 сар тутамд хийдэг энэ өргөтгөсөн хяналтын хурлаар энийг ярьдаг, 2023, 2024, 2025 энэ сүүлийн 3 жилийн сүүлээр ингээд төлбөрүүд хийсэн ажлын төлбөрүүд хийгдэхгүй байна. Яагаад манайх бид нар зээл олгоод байхад энэ төлбөрийг нь хийдэггүй юм бэ гэдэг асуудал ингээд дандаа ярьдаг. Тэгэхээр ингээд энэ Энэтхэгийн Эксим банк Гадаад хэргийн яамны сонирхол нь үйлдвэрийг аль болохоор түргэн ашиглалтад оруулж зээлээ эргэн төлүүлэх мэдээж сонирхолтой. Тэгэхээр ингээд зээлийн зарцуулалт ингээд бага байна гэдэг дээр бол асуудал тавьж байгаа. Бичгээр бас ирдэг юм байна лээ Сангийн яаманд.

Дээрээс нь бид нар ЕРС гэрээгээр үүрэг хариуцлага хүлээсэн байдаг. Манай тал төлбөрийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүнд шаардлага тавих хүндрэлтэй байдаг. Техник тоног төхөөрөмж эд үйлдвэрлэгдээд тээвэрлэж байгаа үед сүүлийн 10 сарын дундаас хойш төлбөр хийгдээгүй ингээд байж байгаа нь бид нарын ажилд маш их хүндрэлтэй байгаа.

Н.Наранбаатар: Тодруулъя. Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Сангийн яамнаас асууя. 15 жилээр үйлдвэр ашиглалтад орохгүй нь ээ. Энэ хооронд Монгол Улс хэчнээн хэмжээний хүү алданги төлөх үү? Дээрээс нь нөгөө алдагдсан боломж гэж ярьдаг шүү дээ. Бид нар ингээд шатахууны хомсдолд ороод л ингээд суугаад байдаг. Энийг тооцож үзсэн үү энэнээс ямар үр

дүн гарах вэ? Ажлын хэсэг үйлдвэр дээр нь очиж газар дээр нь ажилласан. Энэтхэгийн тал бол яг л ийм юм ярьдаг юм. Танайх өөрсдөө төлбөрөө гүйцэтгэхгүй байгаа. Бид бушуухан гүйцэтгээд л танай улсаас явахыг хүсэж байна гэдэг ийм юм ярьдаг байхгүй юу.

Тэгэхээр мега төслүүдийг хийхгүй байна гээд улс төржих маш гоё сэдэв мөртөө бид нар хийх эрх зүйн боломжийг нь бий болгох нь Улсын Их Хурлын үүрэг л гэж бодоод байгаа юм.

Н.Наранбаатар: Сангийн яам 7 номер хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Энэ төсөл дээр яг зээлийн үйлчилгээний төлбөртэй холбоотой үндсэн төлбөр, хүүгийн төлбөр, хөрөнгө баталгаажуулсны шимтгэл гээд 3 төлбөрийн асуудал байгаа. Төсөл яг хугацаандаа ашиглалтад орох ажил хийгээд явж байгаагаас үл хамаарах заавал зайлшгүй төлөөд явах төлбөр үндсэн төлбөр. Хүүгийн төлбөрөө бид нар зээлийнхээ гэрээ хэлэлцээр хугацаагаар төлнө. Бид нар яг ашиглаагүй үлдэгдэл 4.7 их наяд. Энэ үлдэгдэл өндөр хэмжээгээр ингээд байгаад байх тусам жилд дунджаар хориод тэрбум төгрөгийг энэ шимтгэлд төлж байгаа. Тэгэхээр энийгээ бид нар нийт Монгол Улсын гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт энэ шимтгэлд төлж байгаа төлбөрийн 50 хувь нь зөвхөн газрын тос боловсруулах үйлдвэр. Тэр яагаад гэхээр энэ өөрөө өндөр байгаа учраас. Тэгэхээр бид нар энэ 4.7-г яг богино хугацаанд ашиглаад дуусах нь жилд дунджаар бид нар 20 тэрбум. Нөгөө талдаа эдийн засаг болон нийгмийн үр өгөөжийн хувьд хийсэн судалгаагаар бид нар яг энэ газрын тос.

Н.Наранбаатар: Гүйцгээж хариулъя. Нэг минут.

Ж.Дэлгэржаргал: Төлбөрт яг импортын хэрэглээндээ дунджаар 1 тэрбум ам. долларыг энэ үйлдвэр ашиглалтад орсноор орохгүй байх юм бол жил тутам 1 тэрбум ам долларыг гадагшаа гарах ийм тооцоололтой байгаа. Тэгэхээр энэ бол мэдээж хугацаа хойшлох тусам энэ бол нийгэм эдийн засагтаа үзүүлэх нөлөөлөл нь хэрэгцээгээ дагаад жил ирэх тусам нэмэгдэх эрсдэлтэй байгаа. Тэгэхээр бид нар ашиглалтад хамгийн богино хугацаанд ашиглалтад оруулснаар энэ хэмжээний хэрэглээгээ дотоодоосоо хангаж импортын хэрэглээгээ дотооддоо хангах эдийн засгийн үр өгөөж нь хамгийн энгийн тооцоолол нь энэ байгаа.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн байхгүй байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Гадаад зээлийн ашиглалт, зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Гишүүд үг хэлж дууслаа. Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Би хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа юм. Тэгээд хэдүүлээ тал талаас нь яриад явъя. Тэгээд би яах вэ зүгээр анх ингээд санаачлаад явж байсан гишүүн. Тэгээд өргөн барихад оролцоогүй, оролцохоос нэрээ татгалзаж байгаа. Харин Байнгын хорооны түвшинд болон Улсын Их Хурлын түвшин дэх ажлын хэсэгт орж ажиллах саналтай байгаа гэдгээ зарчмын хувьд хэлье ээ. Тэгээд хэдүүлээ энэ нэг асуудлыг шийдье. Ер нь ийм агуулгатай хууль хэд хэд гарч байсан юм байна лээ шүү. Энийг тодорхой түвшинд Байнгын хорооны протоколд хэлье.

Алтанхуягийн Засгийн газрын үед гарч байсан ийм хууль байгаа. Тэгэхээр энэ дээр огтоосоо нэг ийм шийдэж байгаагүй юм оруулж ирж байгаа юм шиг биш юм

байна лээ. Өмнө нь ч гэсэн шийдээд явж байсан ийм практик жишгүүд байна аа. Нэрийн хувьд өөр өөр янз янзаар гарч байсан байна лээ. Энэ зүйлийг хэлье. Тэгээд ажлын хэсэгт орж ажиллах саналтай байна аа.

Н.Наранбаатар: Санал хураалт. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг танилцуулна.

15.34 цаг

Хоёр.Үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүнд хийсэн аудитын тайлан

Үндэсний аудитын газрын гүйцэтгэсэн үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж эхэлье ээ.

Төрийн аудитын тухай хуулийн 33.6-д Монгол улсын ерөнхий аудитор энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэсэн аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ гэж заасны дагуу үр дүнд суурилсан төсөвлөлт төлөвлөлтийн шилжилтийн үйл явц үр дүн сэдвээр гүйцэтгэсэн Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд ирүүлсэн. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.2.2-т төрийн санхүү төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг Төсвийн байнгын хороо тухай бүр хэлэлцэнэ гэж заасан.

Хэлэлцэж. Байгаа асуудалтай холбоотойгоор ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Сандагийн Магнайсүрэн Монгол улсын ерөнхий аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор. Банзарын Саруул Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер. Идэрсайханы Туяадарь Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын Үндэсний аудитын менежер, Буянхүүгийн Батдэлгэр Үндэсний Аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын ахлах аудитор.

Үндэсний Аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэн танилцуулна. Индрийн микрофонд урьж байна.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоолоор баталсан аудитын сэдвийн дагуу үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүн сэдвээр гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэж, тайлан дүгнэлтийг үүгээр танилцуулж байна аа.

Тус аудитыг Монгол Улсад төлөвлөлтийн бодлого, төсөвлөлтийн бодлого, үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын тогтолцоонд шилжих хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэх, үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн шилжилтийн үйл явц үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд чиглүүлэн гүйцэтгэлээ.

Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт рүү шилжих үйл явц нь улс орны санхүүгийн хариуцлага төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх чухал шинэчлэл билээ. Энэ нь зөвхөн техник аргачлал бус хувь хүний хандлага, институтын чадавх, засаглалын соёлын өөрчлөлт, удирдлагын манлайлал шаардсан цогц процесс юм аа.

Энэхүү шилжилтийг зөв хэрэгжүүлж чадвал Монгол Улсын төсвийн тогтвортой байдал санхүүгийн хариуцлагын шинэ шатад гарч хөгжлийн бодлогоо илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой болох юм аа. Үр дүнд суурилсан төсөвлөлт нь зөвхөн санхүүгийн зарцуулалтыг хянахаас гадна тухайн төслийн зорилго, хүрэх үр дүн, нийгмийн нөлөөллийг үнэлэхэд чиглэх ёстой. Монгол Улсын төрөөс төсвийн хөрөнгийн зарцуулалтыг сайжруулах үр дүнд чиглүүлэх арга хэмжээг сүүлийн гучаад жилийн турш хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ чиглэлээр хэрэгжүүлэхээр бодлого шийдвэр гаргаж хэрэгжүүлж байгаа боловч шийдвэрийн хэрэгжилт хангагдаагүйгээс дорвитой өөрчлөлт, шинэчлэлт хийгдэхгүй, үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын тогтолцоонд шилжих боломж бүрэн бүрдээгүй нь хөгжлийн хурдыг удаашруулж байгааг Улсын Их Хурал анхааралдаа авах зайлшгүй шаардлагатай байгааг уламжилъя аа.

Тус аудитаар төсвийн төлөвлөлт нь бодлогын зорилго хөтөлбөрийн үр дүнтэй уялдаагүй, зардлын зориулалт, хуваарилалт, богино хугацааны хэрэгцээ, уламжлалт арга барилд суурилсан хэвээр байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын тогтолцооноос хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийг 4 түвшинд урт, дунд, богино хугацааны бодлоготой уялдуулан боловсруулахаар зааснаас, өөрөөр үр дүнд суурилж төсөвлөх гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний болоод удирдлагын мэдээлэл шийдвэр дэмжих систем зэрэг бусад тогтолцоог бүрэн бүрдээгүй байна.

2.Хөтөлбөрийн өртгийг тооцох зардлын норм нормативт хэмжээг тооцоолж баталгаажуулаагүй нь бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх санхүүгийн нөөцийг төлөвлөх боломжгүй болгож хэрэгжилт удаашрах, өртөг нэмэгдэх нэг шалтгаан болж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчид хөтөлбөрийн хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох ёстой боловч ихэнх нь нөхцөл байдлын шинжилгээ судалгаанд суурилаагүй хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж чадаагүй шалгуур үзүүлэлтийг хангасан жишиг хөтөлбөр байхгүй байна.

3.Засгийн газрын бүтцийн хөгжлийн бодлого стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиг үүрэгт нийцүүлэн зохион байгуулаагүй, төрийн эрх мэдлийг өргөжүүлэх үүднээс бүх асуудлыг шийдэх гэж хичээн эхэлснээ дуусгалгүйгээр нэгэн

зэрэг олон төсөл санхүүжүүлэхээр төлөвлөж төсвийг үр ашиггүй байдлаар төлөвлөсөн хэвээр байна.

4.Хөгжлийн бодлого төсвийн төлөвлөлтөд оролцогч бүх талуудыг нэгтгэн мэдээллээр хангах, удирдах цогц мэдээллийн систем үүсээгүй нь үр нөлөөтэй, хяналтын болон хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх боломжийг боломжийг бууруулж үнэлгээ нь зөвхөн бодлогын баримт бичигт оноо өгөх төдийхнөөр хязгаарлагдаж байна аа. Тус аудитаар үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын тогтолцоонд шилжих үйл явц богино хугацаанд хэрэгжих боломжгүй байгааг харгалзан үе шаттайгаар шилжих бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс эхний ээлжид Улсын Их Хуралд 3 асуудал толилуулж Монгол Улсын Ерөнхий сайдад 3, Эдийн засаг, хөгжлийн сайдад 2, Сангийн сайдад 2 зөвлөмжийг тус тус хүргүүлээд байна аа. Тайлантай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг асуултаар манай аудит хийсэн багийнхан асуултад хариулахад бэлэн байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Ерөнхий Аудитор Магнайсүрэнд баярлалаа. Аудитын тайлантай холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт үг нэг байгаа. Заяабал гишүүнээр тасаллаа. Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ж.Батжаргал: Тусдаа биш билүү. Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Аудитын байгууллагаас тодорхой сэдвүүдээр тов тодорхой аудитууд хийгдээд тэгээд дүгнэлт зөвлөмжүүд гараад яваад байгаа юм. Тэгээд бид нар түүнийг авч хэрэглэх тал дээр нэлээн жоохон дутуу ажиллаад байна уу даа гэмээр юм байгаад байгаа. Тэгэхээр ерөөсөө энэ үр ашгийг дээшлүүлье энэ төлөвлөлтийн бодит байдлыг хангая энэ тэр гээд ингээд ярих юм бол ер нь ингээд болж өгөхгүй байгаад байгаагийн утга учир нь энэ төлөвлөлтийн хийгээд Төсвийн хууль тогтоомжийг чинь хаана нь байгаад байгаа юм гэдэг асуудал байгаад байгаа байхгүй юу. Энүүнийгээ өөрсдийгөө шүдтэй болгох гэдэг юм уу ер нь энэ төлөвлөлт юмнуудаа бодитой болгох үүднээс ямар заалтууд энэ тэр оруулмаар байгаад байгаа юм бэ? Энэ дээр одоо мөн ч олон жил нийцлийн хийгээд гүйцэтгэлийн аудит хийчихсэн байгууллага тов тодорхой санал, дүгнэлт юмнуудаа оруулж ирэх юм уу? Зүгээр дүгнэлт зөвлөмж өгчхөөд тэрийгээ хэрэгжүүлэхгүй байна гээд суугаад байх юм уу? Яамаар юм бэ дээ. Нэг ийм зүйл байгаад байх юм.

Хоёрдугаарт Магнайсүрэн дарга Ерөнхий аудитор болохдоо том том төсөл юмнууд дээр урьдчилсан аудит хийдэг тухай нэлээн ярьсан юм. Үгүй тэрийг хэдүүлээ ямар баримт бичгүүдэд хуулиудад тусгах вэ? Тийм тодорхой саналууд байна уу? Тэрийг л би нэг жоохон Монголд өгөөжөө өгөх болов уу гэж бодоод байгаа юм. Бэлтгэл хангагдаагүй гэдэг юм уу. Үр ашиг нь тодорхойгүй судалгаа тооцоолол дутуу ийм юм руу одоо гадна, дотнын үнэ цэнтэй хөрөнгүүдийг хаячхаад байхгүй байх боломж нь бүрдэх ёстой юм. Тэгэхээр энэ тал дээр та хэдэд анхаарч байгаа юм байна уу? Тов тодорхой ийм хуульд ийм заалт ийм юм оруулах ёстой ингэж байж энэ хангагдах ёстой гэвэл ний нуугүй үнэнийг хэлэхэд олонхын бүлэг дэмжиж наадхыг чинь ажил болгомоор байна. Нэг ийм тодорхой дүгнэлт зөвлөмж өгөх бололцоо бий юу?

Нэг ийм 2 асуултад ерөнхий хариулт авчихмаар байх юм.

Н.Наранбаатар: Ерөнхий аудитор хариулна. 5 номер.

С.Магнайсүрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Сүүлийн асуултаас нь эхэлчихье. 1 дүгээрт урьдчилсан аудит хийх асуудал аягүй чухал асуудал байгаа. Улсын Их Хурлын гишүүд энэ тал дээр саналаа нэлээн илэрхийлсэн. Бид өнгөрсөн тэрний өмнөх 7 хоногт Төсвийн байнгын хороогоор 2026 оны аудит хийх сэдвээ бодлогын сэдвүүдээ батлуулсан. Энэ 9 сэдэв дотор бид нар нэг урьдчилсан аудитын сэдэв оруулж батлуулсан. Тэр нь бол нийслэл дээр хэрэгжиж байгаа Туулын хурдны замд төслийг яг эхлээгүй байгаа. Одоо эхлэх гэж байгаа. Энэ төслийг урьдчилсан аудит хийе гэж ингэж сэдэв орсон. Өнөөдрийн байгаа эрх зүйн орчны хүрээнд бол яг урьдчилсан аудит хийх энэ боломж байгаа гэж бид харж байгаа учраас сэдвээ оруулсан. Бид Төсвийн байнгын хороон дээр байж байгаад Төсвийн байнгын хорооны дараагийн бололцоотой үед нь бид аудитынхаа үйл ажиллагааны явцын талаар тулгамдаж байгаа асуудлын талаар мэдээлэл хийхээр цаг санал хэлээд тохиролцсон. Энэ хүрээнд бид нар хэд хэдэн хуулийн төсөл дээр зарим өөрчлөлтүүд шаардлагатай байна гэдэг ийм саналыг бэлдэж оруулж ирэх гэж байгаа. Энэ хүрээнд нарийвчилсан тийм дутмаг зохицуулалт байвал бид нар энэ урьдчилсан аудиттай холбоотой асуудлыг хөндөнө.

Одоогийн байгаа эрх зүйн орчны хүрээнд бид нар аудит хийх явцынхаа хүрээнд төрийн аудитын хууль болоод энэ бусад дүрэм журмын хүрээнд бол урьдчилсан аудит хийх бололцоотой юм байна гэж үзээд ингээд явж байгаа юм. Ер нь бол урьдчилсан аудитыг олон хөгжингүй улс орнууд хийгээд энэ үр дүнтэй юм байна гэдэг ийм байдлаар үнэлэгдчихсэн, ялангуяа Кувейт, Нидерланд гээд бусад олон улс орон хийж байгаа Солонгос, Япон энэ тэр туршлагаас харах юм бол ач холбогдолтой үр дүнтэй гэдэг нь нотлогдчихсон.

Тийм учраас энэ туршлага нэлээн дэлгэрч байгаа. Олон улсын аудитын дээд байгууллагаас бусад улс оронд энийг бол жишиг чиглэл болгож хөгжүүлэх ийм юу гарчихсан. Олон улсын аудитын дээд байгууллагын бид нарын мөрддөг чиглэл зарчим дотор урьдчилсан аудит хийх ёстой. Бодит цагийн аудит хийх ёстой гэдэг ийм зүйлүүд орчихсон ингээд явж байгаа. Тийм учраас бид нар энэ жил бол гишүүний хэлсний дагуу томоохон төсөл буюу 676 сая долларын ийм өртөгтэй энэ төсөл дээр хийж эхэлье гэдэг ийм байдлаар орсон. Бид нар олон төслийг оруулж болох байвч хөрөнгө мөнгөний бололцоо хүний нөөц чадах бололцоогоо бодож үзээд энэ жил нэг том төсөл дээр хийгээд эхэлье гэсэн ийм байдлаар орж байгаа.

Хоёр дахь асуудал дээр ер нь дүгнэлт зөвлөмжүүд бид нар ингээд гаргаад аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар бүтэцтэй зохион байгуулаад ингээд бид нар тусгайлан авч үзээд өнөөдрийнх хүртэлх бүх өмнө нь биелэгдээгүй байгаа аудитын шийдвэрүүдээ нэгтгэж, дата мэдээлэлтэй болоод, энэ дээрээ анализ хийгээд өнөөдрийн байдлаар бидэнд нэг 3 мянга орчим хэрэгжээгүй буюу хугацаа дууссан ийм шийдвэрүүд байгаа. Энэ дотор дүгнэлт, зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлага, сахилгын шийтгэл ноогдуулах гэмт хэргийн шинж чанартай гээд ийм 5 хэлбэрээр аймаг, орон нутаг, Үндэсний аудитын газраар нь гаргаад бид нар энэ дээр нэлээн нухацтай ажиллаж байгаа. Энэ асуудлынхаа явцын талаар бид нар Төсвийн байнгын хороон дээрээ танилцуулаад энийгээ бүрэн хэрэгжүүлэхэд зарим хууль эрх зүйн орчин дээр ийм асуудлыг шийдчихвэл ийм үр дүнтэй байна гэдэг байдлаар бид нар Байнгын хороон дээрээ танилцуулахаар бэлтгэсэн байгаа.

Төлөвлөлт, төсөвлөлтийн бодлоготой холбоотой энэ нарийн мэдээллийг манай Энхболд дарга өгнө. Ер нь бид нар дүгнэлт, зөвлөмж, шийдэл, аудитын шийдвэр гарсан л бол бид нар хэрэгжилтийг хангах талаар хуульд байгаа бүх бололцоогоо нөөц бололцоогоо дайчилж ингэж шахаж ажиллаж байгаа. Төлөвлөлт, төсөвлөлттэй холбоотой бид нар өмнө нь бас энэ төсвийн бодлого төсвийн төслүүд дээр болоод бусад олон асуудал дээр яг энэ чиглэлээр багагүй ийм дүгнэлт зөвлөмжүүд өгсөн байгаа. Гэвч одоо бас хэрэгжихгүй өнөөдрийг хүрсэн нь өнөөдрийн манай энэ нэгдсэн аудитын дүгнэлт дээр нэлээн тодорхой.

Н.Наранбаатар: Нэмэлт хариулт 6 номер. Нэмж хариулъя.

Д.Энхболд: Үндэсний аудитын газрын гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал Энхболд. Батжаргал гишүүний асуултад нэмэлтээр хариулъя аа. Томоохон төсөл хөтөлбөрт урьдчилсан аудит хийх нөхцөл бололцоо байна уу гэдэг дээр бол Төрийн аудитын тухай хуульд гүйцэтгэлийн аудитын олон улсын аудитын дээд агуулгын стандартыг дагаж мөрдөнө өө гээд заачихсан байгаа. Тэгэхээр олон улсын аудитын стандартад нь гүйцэтгэлийн аудит дотроо урьдчилсан аудитыг хийх нөхцөл боломж нь байгаа учраас энийг Улсын Их Хурлаас урьдчилсан аудитын сэдэв захиалга хийхэд бид нарт нэмэлт хуулийн заалт бол хэрэггүй хийгээд явах бололцоотой гэж үзэж байгаа.

Эхний асуултын хувьд бол энэ дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх тал дээр хариуцлагын тогтолцоог сайжруулах тал дээр бол нэлээд анхаарах шаардлагатай. Олон улсын туршлагыг харахад бол.

Н.Наранбаатар: Гүйцээе.

Д.Энхболд: Төрийн аудитын байгууллагын дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх тал дээр Улсын Их Хурлын Байнгын хороодтой хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байдаг. Ийм сайн туршлага байдаг. Тухайлбал аудитын тайлан бүрээр холбогдох Байнгын хороодоор хэлэлцээд Засгийн газарт хугацаатай үүрэг даалгавар чиглэл өгөөд тэр үүрэг даалгаврыг тодорхой хугацаанд хэрэгжүүлээгүй тохиолдолд холбогдох хариуцлагыг хүлээлгэх энэ хуулийн хариуцлагын механизмуудын заалтуудыг илүү нарийвчлах шаардлага байна гэдэг ийм бол асуудал байгаа. Энийг бид нар Төрийн аудитын тухай хуулийн эрх зүйн орчны судалгааг хийгээд Улсын Их Хуралд танилцуулахаар төлөвлөсөн ийм судалгааны ажил дээрээ тусгайлан танилцуулах бодолтой байгаа.

Н.Наранбаатар: Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Одоо их сонин юм байна л даа. Амьдралд баян юм болохоор янз бүрийн юмнууд гарч ирээд байх юм. Зээлийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлбэ гээд. Яах аргагүй ашиглалт удаашрахаар зэрэг өртөг ч өсөж байна. Цаад бий болгох гээд байгаа бүтээн байгуулалт ч үндсэндээ үнэ цэнээ алдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар энэ нэг төсвийн тусгай шаардлага гэж нэг зүйл баталчхаад хязгаарууд тогтоочхоод өнөөхдөө захирагдаад явж чаддаггүй. Тэгээд аргаа бараад нэг удаагийн үйлчилдэг хууль оруулж ирж байна гишүүд. Гэтэл мэргэжлийн байгууллагууд нь яг нарийндаа хөдлөхгүй байна шүү дээ энэ чинь. Сангийн яам нь ч гэдэг юм уу энэ холбогдох байгууллагууд нь. Энэ нэгэнтээ баталчихсан гэрээ соёрхол нь ёсчилчихсон энэ зээлийн хөрөнгийнхөө ашиглалтыг заасан богино хугацаандаа ашиглах талаар төдий л ийм шийдэл гаргахгүй байгаад байдаг. Энэн

дээр та хэд үзэхээрээ бодвол нэг зөрчил ярих байлгүй. Төсвөөс гадуурх төсөв бий болгосон байна гээд ингээд л юм ярих болов уу л гэж би ойлгоод байгаа шүү дээ.

Н.Наранбаатар: Нэг минут Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Хоёр дахь нь та хэд дараагийнх нь тэр Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт гэж байна лээ. Бодвол баахан улсуудыг хэмнэлтийн хууль зөрчсөн байна гээд л ярих байх. Би тэгж л бодоод байгаа. Гэтэл аливаа бүтээгдэхүүн өөрийн гэсэн үнэ цэнтэй. Тэр үнэ цэнээрээ хэрэгжиж байж бодитой ажил болж гүйцэтгэлийн үр дүн ахиу гаргах ёстой. Гэтэл тэрнээс нь бага өртөгжилт тавьчхаад зүтгүүлээд тэгээд гаргасан зардал нь яг нарийндаа өгөөж болж ирэхгүй байгаа ийм зүйлийг яах юм. Баахан төрийн байгууллагууд дээр орон тоо бүтэц тавьчхаад үйл ажиллагааны зардалгүй шахуу болгочхоод байгаа шүү дээ. Ний нуугүй үнэнийг хэлэхэд, бензин шатахуун, томилолтоос авхуулаад. Тэгээд энэ чинь яаж ажлын үр дүн гарах юм, гүйцэтгэлийн үр дүн гарах юм.

Тэгэхээр энийг ер нь хэдүүлээ яаж харах ёстой юм бэ? Нэг тодорхой өөрийн өртөг үнэ цэнэ гэж нэг юм байх л ёстой. Аливаа юманд.

Н.Наранбаатар: 5 номер Ерөнхий аудитор.

С.Магнайсүрэн: Батжаргал гишүүний нэмэлт асуултад хариулъя.

Энэ зээлийн үр ашиг дээр манайх ХАА-н салбараас бусад гаднын зээл тусламжийн үр ашиг гэдэг сэдвээр аудит хийгээд одоо энэ 25-нд энэ Төсвийн байнгын хороонд ирүүлнэ. ХАА-н салбардахыг өнгөрсөн жил хийгээд яачихсан юм билээ. Байнгын хороондоо хүргүүлээд ингээд сонсчихсон. Ер нь олон асуудлууд хөндөгдөж байгаа энэ дээр. Төрийн аудитын байгууллагын тухай төсөвтэй холбоотой асуудлыг аудит хийхэд хуулиараа төсвийн шаардлага нийцэж байгаа эсэх гээд ингээд хуульчилчихсан учраас бид Улсын Их Хурлаас баталсан төсвийн шаардлагад нийцэж байгаа эсэх гээд энэ хязгаарыг нь заавал нийцэж байна, нийцэхгүй байна, болох, болохгүй гэдгийг нь заавал дүгнэж байгаа. Тийм учраас энэ хязгаартай холбоотой асуудал дээр бол хуульчилчихсан хязгаараа л бид нар хэлж байгаа.

Гэтэл Сангийн яамнаас ингээд мэдээлэл сонсохоор нээгдчихсэн, батлагдчихсан, соёрхон баталчихсан төслүүдийн нийт дүнгээс аягүй бага хувийг ашиглачихсан.

Н.Наранбаатар: Гүйцээе.

С.Магайнсүрэн: Гаднын зээл тусламжийн соёрхон баталчихсан эрх бүхий байгууллагуудаас соёрхон баталчихсан төслүүдээс аягүй бага хувийг нь хэрэглэчихсэн ийм юм байдаг юм байна. Тэгээд цаашаа яагаад хэрэглэж болдоггүй юм гэхээр энэ хязгаарт очоод тулчихсан, давчихсан, давчих гээд байгаа ийм гээд асуудлууд яригддаг юм байна лээ. Ийм учраас энэ дээр бол нэлээн тодорхой ярих ийм шийдлүүд Их Хурал дээр хуулийн хэмжээний шийдлүүд хэрэгтэй юм болов уу л гэсэн зүгээр ийм юу байгаа. Миний хувийн бодол. Бид нар дүгнэхдээ бол яг хуульд юу гэж заасан тэрүүгээр нь дүгнэхээс өөр гарцгүй ийм зүйл байж байгаа.

Тэр өртөгжилтийн асуудал дээр бол олон асуудлууд байгаа. Бид нар өнгөрсөн хоёр 7 хоногийн өмнө Төсвийн байнгын хороон дээр энэ төсөвт өртгийн нэмэгдлийн асуудлаар нэлээн багагүй хугацаанд гишүүдэд тайлангаа тавьж хариулт авсан. Энэ бол олон асуудал хаана хаанаа чадавх хариуцлагын асуудал байгаа гэж үзээд бид нар 2026 онд бол энэ нөгөө төсөвт өртгийн нэмэгдлийг оруулахгүйгээр энэ зураг төсөв зохиож байгаа. Тэр нөгөө эх үүсвэр буюу зохиож байгаа тэр тогтолцоо руу нь бид нар тодорхой тийм ерөнхий том сэдэв авч Барилгын хөгжлийн төв гэдэг юм уу эрчим хүчний.

Н.Наранбаатар: Нэмж хариулах уу? 6 номер.

Д.Энхболд: Батжаргал гишүүний асуултад нэмж хариулъя аа.

Энэ үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц үр дүн гэдэг аудит дээр бид нар гол нь энэ жижиг төсөл, арга хэмжээ, зорилтын гүйцэтгэлээр нь тоон үзүүлэлтээр үнэлээд байна аа. Тэгтэл хөгжлийн гол урт дунд хугацааны зорилтоо хэрэгжүүлэх хөтөлбөрүүдэд хуваагдах ёстой. Хөтөлбөрийнхөө тухайн зорилтыг хүнсний аюулгүй байдлыг хангах зорилт байлаа гэхэд тэр хүрээнд хэдэн хөтөлбөр хэрэгжих ёстой юм. Нэг хөтөлбөрт нь ямар өртөг зардал гарах ёстой юм бэ гэдэг энэ өртөг зардлаа хөтөлбөрөөрөө тооцож гарсан үр дүнгээ үр нөлөөгөөр нь тооцох ийм аргачлалыг нэвтрүүлж чадахгүй байна аа. Гэтэл 30 жилийн хугацаанд 1996 онд анх энэ шилжилтийг хийхээр Засгийн газрын бодлого гарсан боловч хүчингүй болоогүй байгаа. 30 жилийн хугацаанд нөгөө л гүйцэтгэлийнхээ тоон үзүүлэлтээр жижиг төсөл арга хэмжээнүүддээ анхаараад олон ийм үйл.

Н.Наранбаатар: Заяабал гишүүн асуулт асууна.

Б.Заяабал: Аудитын байгууллагын нэг аудит хийгдсэн сэдэв орж ирж байна. Өөрөөр хэлбэл төсвийг нь энэ бүгдэд суурилсан төлөвлөлт төсөвлөлт маань ер нь явж байна уу, ер нь зөв явж байна уу гэдэгтэй холбоотой аудит хийгдсэн. Тэгээд энэ аудитын байгууллагын дүгнэлттэй би 100 хувь санал нэг л байна л даа. Бодлогын баримт бичигт оноо өгөх төдийхнөөр хязгаарлаж байна л гэнэ. Хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж чадахгүй байна л гэнэ. Гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, удирдлагын мэдээлэл, шийдвэр дэмжих систем зэрэг бусад тогтолцоо нь бүрэн бүрдээгүй байна л гэнэ. Удирдлагын тогтолцоо нь бүрэн бүрдээгүй байна л гэнэ. Үндсэндээ бол үр дүнд суурилсан төсвийг төсөвлөж чадахгүй байна, төлөвлөж чадахгүй байна гэсэн ийм л дүгнэлтийг та нар хийгээд гаргаад ирчихсэн байна. Тэгээд гаргаад ирчихсэн байна. Тэгээд танай байгууллагын үндсэн зорилго бол энэ төсвийн хөрөнгийг яг л энэ улсын төсвийн хөрөнгийг зүй зохистой үр ашигтай хэмнэлтээр зарцуулж чадаж байна уу үгүй юу гэдгийг чинь л шалгах учиртай ийм байгууллага. Тэгээд төсөв чинь өөрөө ингээд буруу боловсруулагдаад төлөвлөгдөөд төсөвлөгдөөд мэдээж төлөвлөлт нь буруу бол төсөвлөлт буруу, төсөвлөлт буруу бол гүйцэтгэл буруу. Тэгээд үнэлгээ чинь хангалтгүй л гэсэн дүн гарч байгаа шүү дээ. Тэгээд ийм байдлаар л 35 жил явлаа. Аудитын байгууллага. Тэгээд аудитын байгууллагын олон улсын энэ тогтолцоог нь үзээд судлаад үзэхээр зэрэг Ерөнхий аудитор дээр суурилсан ийм тогтолцоо байна аа. Энэ нь өнөөдөр манай Монголын тогтолцоо. Ерөнхий аудитор нь хэмжээгүй эрх мэдэлтэй аудитын байгууллага дотроо.

Ерөнхий аудитроос гадна зөвлөлтэй ийм аудит байна аа. Зөвлөл дээрээ бүх асуудлаа шийдээд явдаг. 3 дахь нь дэргэдээ шүүхтэй ийм аудитын байгууллага

гэсэн ийм 3 янзын тогтолцоо байна шүү дээ. Тэгээд 35 жил бид нар Ерөнхий аудиторын тогтолцоо яваад өнөөдөр үр дүн ямар байна аа? Төсөвлөж ч чадахгүй сууж байна шүү дээ. Олон жил ярьсан шүү дээ үр дүнд суурилсан төсөв гэж олон жил ярьсан шүү дээ. Одоо энэчээнээс эдийн засаг хөгжлийн та нар энэ тайлангаар Эдийн засаг хөгжлийн яам нь ч мэддэггүй юм байна. Сангийн яам нь ч мэддэггүй юм байна, бүх төрийн байгууллагууд нь энэ яаж төсөвлөхөө ч мэддэггүй юм байна. Тэгээд би мэддэггүй ийм хүмүүсийн боловсруулсан төсвийг үр дүнтэй байна уу гэдгийг шалгаад сууна гэдэг бол та нарт угаасаа утгагүй л дээ.

Тийм учраас та нарын энэ үр дүнгээр ч энэ дүгнэлтийн аудитын хийгдсэн үр дүнгээр төлөвлөлтөө яаж хийх юм бэ? Төсөвлөлтөө яаж хийх юм бэ олон улсын ямар ямар аргачлалууд байна гэдэг нь тэр бүр тэр цаашлаад бүр ямар ямар моделиор энийг нь тооцох юм гэдэг нарийн судалгаанууд орж ирэх байх гэж би ингээд харж байсан л даа. Тэгээд уламжлалт нь л ийм байна. Тэгсэн чинь ингэчихсэн байна. Тэгж байгаа бодлогоо өөрчилчихсөн байна. Үр дүнгүй баахан ингээд баахан ажил зэрэг эхлүүлээд хаячхаж гэсэн ийм л нэг ийм дутуу халсан могой шиг л нэг ийм л дүгнэлт орж ирээд л байна л даа. Энэний чинь үр дүн нь ямар ч үр дүн гарахгүй. Дараа жил төсөвлөлт төлөвлөлт чинь огт сайжрахгүй. Та нарын энэ гаргаж ирсэн, дүгнэлтийн үр дүнд.

Н.Наранбаатар: Нэг минут нэмж өгье.

Б.Заяабал: Тэгэхлээр Аудитын газар 1 дүгээрт энэ тогтолцооныхоо асуудал дээрээ эргэж харах цаг болчихсон юм биш үү гэж ингэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт нь та бүхэн энэ дүгнэлтийгээ гаргаж байгаа энэ шийдвэрүүдийгээ өшөө илүү хэрэгжихүйц баймаар байна. Одоо ингээд сургалт хиймээр байна л гэнэ. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн менежмент мэргэшсэн боловсон хүчнийг тогтвортой хөгжүүлэх тогтолцоог бий болгомоор байна л гэнэ. Үгүй нэг иймэрхүү аягүй гоё жижүүрийн ийм гоё үг хэлж байгаа юм. Гэтэл бодит амьдрал дээр энэ нь шал өөр. Одоо Төсвийн тухай хуулийг та нар аваад үз л дээ. Энэ дээр анализ хийж та нар үзэх хэрэгтэй. Төсвийн тухай хууль дээр Сангийн яам төсвийн хязгаарыг боловсруулаад Засгийн газраар оруулж ирж баталж байгаа. Яг тэр хязгаараар чинь тухайн яамдууд төсвөө төлөвлөөд буцаагаад Сангийн яам руу ирүүлж байгаа. Сангийн яам тэрэн дээр нь үндэслээд төсвийг төсөв рүү оруулж байгаа. Тэгээд анх гаргаж ирсэн тэр төсвийн хязгаараа зарим яам дээр нь нэмнэ зарим дээр нь хасна. Төсөвлөлт дээр. Тэгээд төсөвлөлт нь хэрэгжээд явж байтал хэмнэлтийн хууль гэж гарч ирсэн. Хэмнэлтийн хууль гээд 5 сарын 31-ээр хэрэгжээгүй заалтууд байна гээд мөнгийг нь хураагаад авсан.

Н.Наранбаатар: Нэг минут.

Б.Заяабал: Тэгээд үр дүнг нь яг ингээд явцад нь явж байтал ингээд үр дүнг нь таслаад аваад явчхаж байгаа юм. Тэгэхээр энэ дээр та нар ер нь ямар бодолтой байгаа юм бэ? Энэ дээр 1 дүгээрт та нар аудитын тогтолцооны асуудал.

Хоёрдугаарт энэ төсвийн төлөвлөлтийн асуудал, төсөвлөлтийн асуудал, гүйцэтгэл үнэлгээ хийж байгаа энэ асуудал дээр чинь онцгой анхаармаар байна аа. Тэгээд гүйцэтгэл дээр жишээлбэл олон жил энэ төсвийн гүйцэтгэл чинь хангалтгүй явж ирсэн, шүү дээ. Төсвийн хөрөнгө оруулалтын зардал гэхэд л үндсэндээ нэг 50, 60 хувьтай л явж байгаа. Тэгээд 1 баахан дансандаа баахан мөнгө авдаг. Та нарын

аль тайлан дээр нь ч билээ ороод ирчихсэн л байна лээ. Хэмнэлтийн тайлан дээр чинь ч билүү ороод ирчихсэн л байна лээ. Тэгээд ийм буруу яваад байгаа үйл ажиллагаануудыг ер нь цогцоор нь өөрчлөхийн тулд төсөвлөлтийг бид нар дээрээс хийгээд байна шүү дээ. Сангийн яам, дээд Засгийн газрын толгой байгууллагууд хийгээд байна. Зарим орон Швед, Скандиновын орнууд доороосоо бүр доод нэг засаг захиргааныхаа доод нэгжээсээ эхэлж төсөвлөж явж байна гэх мэтчилэн. Энэ дээр нь ямар уялдаа ялгаа байна. Аль нь манайд тохирох юм бэ гэдэг дээр ямар дүгнэлт хийсэн бэ гэсэн ийм асуулт асуух гэсэн юм.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? 6 номер.

Д.Энхболд: Нэгдүгээр асуудлын хувьд тогтолцооны хувьд Монгол Улсын төрийн аудитын байгууллагын Ерөнхий аудиторын тогтолцоотой. 2003 оноос хойш Ерөнхий аудиторын тогтолцоогоор явж байгаа. 1995 оноос Төрийн хянан шалгах хороо байхдаа Хамтын зөвлөлийн тогтолцоотой байсан. Олон улсын чиг хандлага төлөвшлийн хувьд Ерөнхий аудиторын тогтолцооны хувьд илүү боломжтой. Зөвлөх үйлчилгээг байгууллагуудын тогтолцоо суурь шалтгааныг олж тогтоож зөвлөх тал дээрээ бол Ерөнхий аудиторын тогтолцоо бол илүү давуу тал ихтэй гэж бол үздэг ээ. Шүүхийн тогтолцооны хувьд бол аудитын байгууллагын гаргаж байгаа шийдвэр нь шууд шүүхийн шийдвэртэй адилхан гарсан үедээ шууд хүчин төгөлдөр болоод явдаг ийм онцлог давуу талтай хэдий ч сул талууд нэлээн ихтэй байдаг. Тэр яг шүүхийн байгууллагууд болон хууль хяналтын байгууллагатай ижилхэн мөрдөн шалгах хэрэг бүртгэлийн үйл ажиллагаа давхцаад явдаг учраас энэ дээр олон ижил үйл ажиллагааны нөхцөлүүд буй болдог ийм сул талууд байдаг аа. Тэгэхээр энэ дээр бид нар олон улсын чиг хандлагынхаа дагуу Ерөнхий аудиторын тогтолцоотой явж ирсэн.

Хоёр дахь асуултын хувьд бол төлөвлөлт болон төсөвлөлт 2 тусдаа яваад байна гэдгийг аудитын зөвлөмжөөр өгч байгаа. Төлөвлөлт төсөвлөлт 2-ыг холбох гүүр нь бол олон улсын жишгээр дунд хугацаагаар төлөвлөгдөж байж бол илүү үр дүнтэй явж байгаа. Тэгтэл манай дээр бол нэг жилийн төсвийн хуулиараа бол энэ холбогдохгүй яваад байгаа. Харин тайлагналаа бид нар нөгөө цаглаврынхаа хувьд бол дунд хугацаагаар төлөвлөөд тайлагналаа тухайн жил жилээр нь ямар их ахиц дэвшил гарсан бэ гэдгээр тайлагнаад явахгүй бол төлөвлөлтөө жилээр улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө тухайн жилийн төсвийн төлөвлөгөө гээд ингээд жил жилээр төлөвлөөд цаглавартаа бол энэ төлөвлөлтийнхөө асуудлыг бол урт дунд хугацаанд уяж чадахгүй ийм алдаа дутагдал байгаа учраас энийг олон улсын жишгээр нь бид нар энэ тайлангийнхаа дэлгэрэнгүй дотор бол Япон болон Шинэ Зеланд улсын жишээгээр бол дунд хугацааны төлөвлөлтийг үр дүнтэй болгож байгаа асуудлууд дээр нэлээд дэлгэрэнгүй оруулж өгсөн байгаа.

Тэгэхээр энэ хөтөлбөрт хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийгээ бол баталж байгаа дунд хугацааны үр дүнгээ харж чадахгүй байна аа. Тийм учраас энэ төлөвлөлт, төсөвлөлтийнхөө гүүр болсон энэ дунд хугацааны бодлогыгоо илүү авч явах шаардлагатай байна гэдэг ийм дүгнэлтийг бол аудитор өгч байгаа.

Н.Наранбаатар: Аудитын тайлантай холбогдуулан гишүүд асуулт асууж, асуулт асууж, үг хэлж дууслаа. Үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц үр дүн сэдвээр хийсэн аудитын гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж дууслаа.

**Гурав.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт,
үр дүнд хийсэн аудитын тайлан**

Гурав дахь асуудал Үндэсний аудитын газрын гүйцэтгэсэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн үр дүн сэдэвт нийцлийн аудитын тайлан хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсэг дахиж танилцуулах уу? Өмнөхөөрөө гээд явчих уу? Өө солигдож байгаа юм байна. Ажлын хэсгээ оруулаарай. Ажлын хэсэг Занданбазарын Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор орж ирж байна. Нямдаваагийн Анхбаяр байна уу? босоорой. Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын аудитын менежер, Онхооны Баярмаа Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор, Жаргалын Энхтуяа Үндэсний аудитын газрын Тамгын газрын ахлах шинжээч, Пунцагбаатарын Норовпил Үндэсний Аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын аудитор, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын тайланг Монгол Улсын ерөнхий аудитор Магнайсүрэн танилцуулна.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Тус аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны аудитын сэдэв батлах тухай 5 дугаар тогтоолыг үндэслэн гүйцэтгэж дүгнэлт зөвлөмжийг гаргалаа.

Тус аудитыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан эсэх, хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан эсэх, Засгийн газрын болон бусад төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнтэй байсан эсэх гэсэн чиглэлүүдээр хийж дүнг үүгээр танилцуулж байна аа.

Монгол Улсын Их Хурал төрийн хэмнэлтийн тухай хуулийг төрийн бүх шатын байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор 2022 оны 4 сарын 29-ний өдөр баталсан бөгөөд 2022 онд нэг удаа, 2023 онд 2 удаа, 2024 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Хуулийг дагаж мөрдөх хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 72 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоолоор бүх шатын төсөв захирагч нарт үүрэг чиглэл өгч холбогдох арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болгосон байдаг аа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2022 онд 61.6 тэрбум төгрөг, 2023 онд 56.8 тэрбум төгрөг, 2024 онд 91.1 тэрбум төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлэн дүгнэлт зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна аа.

Аудитад Монгол Улсын 2022, 2023 оны Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн Аудитын тайлан Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022-2024 онд хэрэгжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа зарим байгууллагууд болон холбогдох бусад байгууллагыг түүвэрт хамруулан хийж гүйцэтгэлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүн сэдэвт аудит 1784 байгууллагыг түүвэрт хамруулж нийт 91.1 тэрбум төгрөгийн 416 зөрчил илрүүлж 5.5 тэрбум төгрөгийн 91 зөрчилд төлбөрийн акт тогтоож 32.9 тэрбум төгрөгийн 97 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 52.6 тэрбум төгрөгийн 228 зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа.

2025 оны 12 сарын 22-ны байдлаар 1.6 тэрбум төгрөгийн төлбөрийн актыг биелүүлж улсын төсөвт төвлөрүүлсэн дүн мэдээтэй байна аа. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитын тайлангийн тайланг үндэслэн дараах дүгнэлтийг гаргалаа.

Үүнд төсвийг төлөвлөх, захиран зарцуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар төсвийн сахилга бат сайжрахын зэрэгцээ арвилан хэмнэх нөөцийг үр ашигтай ашиглах нөхцөл бүрдэхээр байна.

2.Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим зүйл заалт, Төсвийн тухай хуулийн зарим зохицуулалттай давхардаж байгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлж боловсронгуй болгох шаардлагатай гэж үзсэн.

3.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас баталж мөрдүүлэх хэм хэмжээний акт батлагдаагүйгээс хуулийг хэрэгжүүлэхэд тодорхойгүй байдлыг үүсгэж байна.

4.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг нэг мөр мөрдөж хэрэгжилтийг хангахгүй байгаа нь төсвийг төсвийн сахилга баттай, үр ашигтай, ил тод, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж нийтийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах нөхцөлийг үүсгэж байна.

5.Засгийн газар болон түүний харьяа байгууллагууд төрийн хэмнэлтийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлээгүй хяналт тавьж ажиллаагүйгээс төрийн байгууллагын санхүүгийн нөөцийн үр өгөөжийг бууруулж байна.

6.Засгийн газрын болон ТӨБЗГ нь зарим төрийн өмчит хуулийн этгээд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай ижил чиг үүрэг бүхий хяналтын менежер, бүтээмж хариуцсан менежер, засаглалын менежерийн орон тоог шинээр бий болгож чиглэл өгч шийдвэр гаргасан нь уг хуулийн үзэл баримтлал үндсэн зорилготой нийцэхгүй байна.

7.Зарим аймгийн Засаг дарга нар ЗДТГ-ын бүтэц орон тоог батлахдаа Засгийн газраас тогтоосон хязгаарт төрийн үйлчилгээний албан хаагчийн орон тоог хамруулахгүй байгаа нь төрийн албан хаагчийн тоо нэмэгдэх нэг шалтгаан болсон байна аа. Тус аудитын дүн дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдад 6, Сангийн сайдад 3, ТӨБЗГ-т 1, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11

хуулийн этгээдийн удирдлагад тус бүр 2 зөвлөмж нийт 12 зөвлөмжийг өгч ажиллалаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Магнайсүрэн даргад баярлалаа.

Аудитын тайлантай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Заяабал гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Батжаргал: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ямар байна вэ гэж гэдэг асуудал дээр аудит хийгээд дүгнэлт тайлангаа оруулж ирж байгаа юм аа. Аудитынхаа дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх тал дээр Улсын Их Хурал ч тэр, Засгийн газар ч тэр анхаармаар байгаа юм. Тэгээд энэ нэг олон яригдаад байгаа асуудлууд өөрөө үндсэндээ стандарт гэдэг юм уу техникийн зохицуулалт болж гарах ёстой. Зарим хэсэг нь. Зарим хэсэг нь энэ эрх зүйн шийдвэрүүддээ тусаж орох ёстой.

Тэгэхээр энэ талынх нь асуудлыг ер нь Төсвийн байнгын хороо бүхэл бүтэн нэг институцийн оруулж ирээд танилцуулж байгаа юмыг сонсчхоод сонслоо гээд алх цохичхоод байх юм уу ер нь бол холбогдох газруудад нь чиглэл өгч байх ёстой юм уу гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгж байж энэний үр өгөөж дээшлэх ийм нөхцөл юмнууд нь хангагдах ёстой гэж. Тэгээд яах вэ дээ өнөө дугуйны л үлгэр л болох гээд байна л даа. Манай аудитынхан бол юм хэмнэсэн горим журмаа их сайн барьсан улсад их дуртай. Гэтэл амьдрал тийм биш байхгүй юу. Яг нарийндаа.

Тэгэхээр төр өөрийнхөө чиг үүргийг дэвшүүлсэн зорилтот түвшнээ хангах чиглэл дээр тодорхой хэмжээний хөрөнгө мөнгө нь хүрэлцэж байгаа юм уу үгүй юм уу гэдэг асуудал өөрөө гарч ирж байгаа юм. Яг нарийндаа энэ төрийн хэмнэлтийн хууль бол энд л бид хэд сайхан байгаад байгаа болохоос биш орон нутгууд дээр байдлыг маш хүндрүүлсэн шүү дээ наадах чинь. Тэгээд энэ мэнийг нь их бодитой дуугармаар байгаа юм. Тэгэхгүй бол энэ төрийн үйлчилгээ нэгжүүд дээрээ очиж доголдох, үйлчилгээ хүртэх ёстой улсууд дээрээ чанартай үйлчилгээ авч чадахгүй нөхцөлийг бий болгоод тэрийг нь хянаж байгаа гэдэг юм уу эс үгүй бол нийцэл юмыг нь хараад байгаа улсууд нь дуугарч өгөхгүй болохоор зэрэг зөв юм шиг ойлгоод ингээд яваад болж өгөхгүй байгаа юм аа.

Энүүнийг ер нь нэлээн зөв талаас нь харж дуугарах ёстой гэдэг санааг би бодоод байдаг. Дээр нь энэ төрийн зарим байгууллагуудыг бид гүйцэтгэл дээр суурилсан санхүүжилтийн тогтолцоо руу шилжүүлээд эхэлсэн. Дам дамаа эрүүл мэндийн байгууллага энэ тал дээр нэлээн алхам хийгээд яваад байгаа. Гэтэл энэ нь үнэхээрийн болж байгаа юм уу болохгүй байгаа юм уу гэдэг асуудал гарч ирж байгаа байхгүй юу.

Зарим жаал тоног төхөөрөмжтэй гэдэг юм уу боловсон хүчний чадамжтай эмнэлгүүд нь болохоор.

Н.Наранбаатар: Нэг минут.

Ж.Батжаргал: Өөр дээрээ төвлөрүүлчхээд байдаг. Тэр иргэддээ хамгийн ойр байгаа эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чиг үүрэгтэй эмнэлгүүд нь

бараг санхүүжилтгүй шахуу байгаад байгаа юм. Монгол өөрөө газар нутаг өргөнтэй бас алс хязгаартаа тархан байршсан, байршилтай ийм улс орны хувьд бол иргэд нэг ижил үйлчилгээ л авах ёстой уг нь бол. Гэтэл тэгж чадахгүй байдлыг бид нарын энэ хийгээд байгаа үйл явцууд өөрөө гаргаж ирээд байгаа юм биш биз дээ гэдэг санаа зарим тохиолдолд бууж ирээд байгаа юм аа. Тэгэхээр энэ талын юмнуудыг энэ манай дам дамаан аудитын байгууллага эд нар их тодорхой гаргаж ирж энэ үндэсний стандарт гэдэг юм уу энэ зохицуулалт гэдэг юм уу энэ юмнуудыг нь зөв болгох чиглэл дээр илүүтэй энэ зөвлөмж дүгнэлт нь.

Н.Наранбаатар: Хэдэн номер. Санал уу? Асуулт уу? Ерөнхий аудиторын орлогч Цэдэнжав 5 номер.

3.Цэдэнжав: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Төрийн аудитын байгууллага Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоолын дагуу Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт үр дүн гэсэн аудитыг хийсэн. Энэ аудитын нэгдсэн дүгнэлтээр бол төрийн хэмнэлтийн хуулийг анх баталж мөрдүүлсэн. Төсвийн арвилан хэмнэлттэй зарцуулах, үр ашигтай зарцуулалтыг дэмжих энэ эрх зүйн орчин бүрдсэн боловч хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна гэж үзсэн. Сая Ерөнхий аудитор танилцуулсан төрийн аудитын байгууллагын дүгнэлтэд бол энэ асуудлаар оруулсан байгаа. Энэ аудитын дэлгэрэнгүй тайланд бол энэ Төрийн хэмнэлтийн хуулийн зарчим төрийн хэмнэлтийн хуулийн энэ хэмнэж болох энэ зардалтай холбоотой зардлын зүйл ангиар гарсан зөрчил дутагдлыг бид нар дэлгэрэнгүй танилцуулсан байгаа. Энд бол автомашин ашиглахтай холбоотой болон хэмнэж болох зардлыг хэмнэхтэй холбоотой асуудлууд байгаа юм.

Зүгээр энэ хууль өөрөө гараад 6 удаа өөрчлөлт орсон. Энэ өөрчлөлтүүд бол тодорхой шаардлагууд байсан. Гэхдээ амьдрал дээр яг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа. Манай хуулийн нөгөө хариуцлага тооцох энэ механизм энэ юун дээр бол зөвхөн Төрийн албаны тухай хуулийн тухай асуудал гэмт хэргийн шинжтэй бол бусад хууль тогтоомжид заасан хариуцлагын тухай асуудал байгаа. Мөн энэ хуульд заасан энэ төрийн үйлчилгээг хэмнэж болох сая Батжаргал гишүүний яг асуулт санал юунд ч орлоо. Энэ төрийн үйлчилгээг хэмнэснээр иргэдэд очих тэр үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулж болохгүй гэсэн энэ зарчмыг бол энэ зарим зүйл дээр бол үнэхээр алдагдуулж байгаа юм аа. Ялангуяа одоо энэ төсвийн хэмнэлттэй холбоотой, зардлын бууралттай холбоотой төрийн үйлчилгээг хүрч очих энэ иргэд олон нийтэд хүрэхгүй байх энэ зам бол үнэхээр алдагдах ийм боломжийг бол бий болгосон ийм асуудал байгаа.

Төрийн хэмнэлтийн хуульд ижил тэгш мөрдөгдөөд ийм асуудал байгаа. Үнэхээр төрийн байгууллагуудын зарим нь бол энэ хуулийг хэрэгжүүлээд явахад зарим нь үнэхээр тэвчиж болох зардлыг тэвчихгүй.

Дээрээс нь өр төлбөр үүсгэдэг охин хараат компаниуд дээр бол өр төлбөр үүсгэж санхүүжилт олгодог гэх мэт олон зөрчил энд илэрсэн. Энэ акт албан шаардлагын зөвлөмжийн биелэлтийг бол бид ирэх оны 2 сарын 2-нд гаргаж ирүүлнэ. Акт албан шаардлагынхаа биелэлтийг бол сая манайхан танилцуулсан байгаа. Энэ гүйцэтгэлд суурилсан санхүүжилттэй холбоотой энэ асуудал бол яалт ч үгүй бид нар сая энэний өмнө бид нар үр дүнд суурилсан санхүүжилт өмнөх юун дээр Заяабал гишүүн ярьсан. Та бүхэн хэлсэн. Энэ Монгол Улс өөрөө энэ төсвийн төлөвлөлтийн энэ тогтолцоон дээрээ хэрэгжвэл бид нар үнэхээр авч үзэх зарчим байна, асуудал байна гэдгийг бол хэлсэн. Энд ялангуяа хамгийн чухал зүйл бол энэ

удирдлагын манлайллын асуудал байгаа. Энэ шийдвэр гаргагчдын энийг одоо түлхэж дэмжиж өгөх энэ асуудал чухал байна гэдгийг бол бид тавьсан байгаа. Энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой аудитын шийдвэр заавал хэрэгждэг байх энэ тогтолцоог бол сая Ерөнхий аудитор танилцуулсан. Бид удахгүй Төсвийн байнгын хороондоо энэ асуудлаа танилцуулж ер нь төрийн аудитын байгууллагад аудитын шийдвэрийг хэрэгжүүлэхэд бидний удирдах байгууллага, Улсын Их Хурал Улсын Их Хурлын Байнгын хороод болон иргэд олон нийтийн зүгээс тавих хяналтыг сайжруулах асуудал чухал байгаа.

Ер нь бол энэ төсөв захирагчийг энэ өмч хөрөнгө гүйцээгээд нийтийн өмчийг захиран зарцуулж байгаа энэ этгээдүүд өөрөө санхүүгийн сахилга батыг хангадаг ёс зүй хариуцлагатай байх энэ тогтолцоог хэрэгжүүлэх нь чухал юм гэдгийг тавьсан. Би энэ аудитын дүгнэлтээр өөрөө Засгийн газраас энэ Төрийн хэмнэлтийн тухай хуульдаа тавих хариуцлага бол алдагдуулсан байна. Мөн Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар Сангийн яамны зүгээс бол энэ хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг өгсөн байгаа. Наранчимэг дарга тодруулах уу?

Н.Наранбаатар: Тодруулах уу хариулт хангалттай юу. Батжаргал дарга. Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Аудитын байгууллага ямар ч байсан ингээд гол хуулиуд дээр аудит хийж ингэж хэрэгжилт дээр нь аудит хийж орж ирж байгаад их сайшаалтай байна. Сая төсвийн төлөвлөлт, төсөвлөлттэй холбоотой үйл ажиллагаан дээр аудит хийж танилцуулсан. Одоо ингээд Хэмнэлтийн тухай хууль дээр орж ирж байна. Тэгээд бид бол яг энэ 35 жил яваад ирчихсэн. Тэгсэн мөртөө бүгдээрээ ярихдаа үр дүнд суурилсан ийм төсөвлөлт хийж байна. Үр дүн гаргахын төлөө төсвийг бид нар захиран зарцуулж байна гэдэг л ийм л үг бид нар хэлж ирсэн боловчиг яг бодит амьдрал дээрээ бид нар үр дүнд суурилсан төсөвлөлт хийж чаддаггүй гээд аудитын байгууллага сая дүгнэлт өгчихлөө.

Тэгээд эндээсээ эхлээд аудитын байгууллагыг шинэ өнгөөр харж байна шүү. Тэгээд та бүхний гаргаж байгаа шийдвэр хэрэгждэг байгаасай гэж ингэж бодож байгаа юм. Тэгээд энэ дээрээ аудитын байгууллага бодлоготой явж байгаа юм байна. Би бол энэ аудитын тайлангууд ер нь орж ирэхдээ энэ ядаж энэ төсвийн Байнгын хорооны тогтоол хэлбэрээр орж ирж байвал яасан юм бэ гэсэн ийм саналтай байдаг. Энэ дээр та бүхэн саналаа хэлнэ биз.

Хоёрдугаарт нь энэ төсвийн хэмнэлтийн тухай хуулийн энэ хуулийнх нь үндсэн зорилго нь энэ төсвийн сахилга бат, энэ үргүй зардлыг бууруулах энээ тэрээ гээд л ер нь төсвийг зөв ашиглахтай холбоотой батлагдсан хууль. Аудитын байгууллагын үндсэн үүрэг ч гэсэн энэ төсвийг үр ашигтай зөв зарцуулж чадаж байна уу үгүй юу гэдэг дээр хяналт тавьдаг ийм байгууллага. Үндсэндээ хэмнэлтийн тухай хууль бол танай байгууллагыг бараг ажлаа хийж чадахгүй байгаа учраас хуулиар дахиж ийм нэмэлт хууль гаргаж зохицуулалт өгсөн юм шиг ийм л агуулгаар ойлгогдож байгаа. Тэгээд би бол энэ хууль ингээд гарчихсан. Ковид цар тахлын үед ч улс орнуудын нэг хэмнэлтийн асуудал гээд тусдаа бие даасан ганц нэг улсууд хууль гаргаж байсан. Тэрнийг дагаад манайх хэмнэлт ковидын үед бол нэг татгалзъя. Үр ашиггүй, зайлшгүй шаардлагагүй зарцуулалтуудаасаа татгалзъя гэдэг ийм агуулгаар гарсан хууль. Энэ хууль маань одоо би та бүхний дүгнэлтийн үр дүнд

энэ хууль үүргээ гүйцэтгэхийг ингээд зогсох ёстой гэсэн ийм дүгнэлт орж ирэх байх гэж ингэж харж байсан. Та нарын дүгнэлтийг бүгдийг нь уншсан.

Тэгсэн чинь та нар тийм дүгнэлт оруулж ирсэнгүй ээ. Хууль дээр байдаг өрөөний метр квадратыг заасан журам жишиг нь батлагдаагүй байна. Тэрийгээ батал энээ тэрээ гэсэн дандаа нэг ийм нэг жижүүрийн нэг ийм юмнууд орж ирсэн, байх юм. Дүгнэлтүүд бичиж орж ирсэн байх юм. Жоохон тийм алсыг харсан бодлоготой юм хиймээр байна аа. Тэгээд нэгэнт төсвийнхөө үр ашгийг бүрэн та нар хянаж чадаж байгаа юм бол одоо Хэмнэлтийн тухай хууль чинь тэр эдийн засаг санхүүгийн хүндрэлтэй тэр цаг үе чинь больчихсон. Төсвийгөө зөв зарцуулж чадаж байна уу үгүй юу гэдэг дээр та нар бүрэн хяналт тавих ийм үүрэгтэй байгууллага.

Одоо тэгвэл энэ хэмнэлтийнхээ хуулийг больчихвол яасан юм бэ? Зогсоочихвол яасан юм бэ гэсэн ийм дүгнэлт гарч орж ирэх ёстой гэж би ингэж харж байсан. Тэгээд та нар энэ дээрээ саналаа хэлээч гэдэг ийм асуулт байна. Тэгээд хууль гаргачхаад ингээд хэрэгждэггүй. Одоо хэмнэлтийн.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? 5 номер.

3.Цэдэнжав: Тийм л байсан. Заяабал гишүүний асуултад хариулъя. Энэ төсөвлөлттэй холбоотой асуудлыг өмнө нь ярьсан. Энийг бид нар анхаарч бодлогын түвшинд цаашаа хэрэгжүүлж явна аа. Ер нь Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо бол манай төрийн аудитын байгууллагын үндсэн харьяалах Байнгын хороо учраас бид Байнгын хороотойгоо энэ бодлогын чанартай асуудлаар бол танилцуулгуудаа шуурхай хийж ингэж хамтарч ажиллана аа.

Ер нь тэр төрийн аудитын байгууллагын энэ аудитын дүгнэлтийг Байнгын хороонд энэ танилцуулах энэ процесс өөрөө олон улсын аудитын дээд байгууллагын сайн туршлага юугаар үзэхэд бол парламентын тогтоол хэлбэрээр гарч энэ хууль хэрэгжүүлэхгүй байгаа Засгийн газар, Засгийн газрын харьяа байгууллага, нөхдүүдэд хариуцлага, хугацаатай хариуцлагын тогтолцоог бий болгох асуудал чухал байгаа юм аа. Энийг бол бид танилцуулах дараагийн асуудлууд дээр бол Ерөнхий аудитор танилцуулна гэж байгаа. Үнэхээр энэ хууль ковидын ковид цар тахлын нөлөөллийг бууруулахтай холбоотой тэр хүндрэлийг даван гарах үед гарсан ийм хууль учраас энэ хуулийн түрүүн Батжаргал гишүүн хэлсэн. Яг ажил үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчийн ААН-үүдэд бол хүндрэл үнэхээр гарч байгаа юм аа. Одоо энд гарсан энэ зөрчил, дутагдал, энэ юмнуудыг үзээд тэр болгон дээр нь одоо акт тогтоох энэ асуудал ярих юм бол төвөгтэй зүйлүүд нэлээн байгаа. Энийг бид нар ойлгож байгаа. Манай аудит хийсэн багаас бас тайлбар хийх байх. Ер нь Төсвийн байнгын хороо энэ манай тайлан дүгнэлтийг сонсоод цаашдаа энэ хуулийг өөрчлөх эсвэл үйлчлэлийн тухай асуудлаар хууль санаачлах бүрэн эрх манай Улсын Их Хурлын гишүүдэд байгаа учраас энэ асуудлыг бол биднийг дэмжиж гаргаж явах байх гэж бодож байна аа.

Н.Наранбаатар: Нэмж хариулт өгье. Хэн хариулах вэ? Хариулт хангалттай юу? Заяабал гишүүн тодруулъя.

Б.Заяабал: Би нэг товчхон тодруулга асуугаадахъя. Сая энэ Хэмнэлтийн хууль дээр харахад тэр жишээлбэл өрөөний метр квадрат энээ тэрээ стандарт тогтооно гэххээд тогтоогоогүй байна гэсэн юм ярьж байна шүү дээ. Хууль хэрэгжээд

хэдэн жил 4, 5 жил болчхов уу. Яг энэнтэй адилхан ингээд хууль нь гарчхаад дүрэм журам нь гараагүй аягүй олон хууль журмууд байдаг юм байна амьдрал дээр. Одоо малчдын тэр тэтгэврийн асуудлаас эхлүүлээд тэр чинь тэр хууль нь гараад 4, 5 жил болчихсон. Одоо хүртэл ингээд журам нь гардаггүй. Хөдөө, сонгогчид орон нутгийнхнаас дандаа байнгын асуудаг. Гэх мэтчилэн. Одоо ингээд зөндөө хуулиудыг ярьж болно л доо. Би хэд хэдэн хуулиудыг ярьж болно. Тэгээд ингээд араас нь бид нар ингээд хөөцөлдөөд л дараа нь аудит орсон нэртэй ороод энийгээ батлаагүй байна батлаарай гээд Ерөнхий сайдад нэг зөвлөмж өгдөг. Тэгээд ийм хэлбэрээр ингээд яваад байх нь зөв юм уу л гэсэн ийм л асуулт надад ургаж гарч байгаа юм.

Тэгээд энэ дээр яавал зүгээр юм бол доо. Аудитын байгууллагын зүгээс энэ дээр ер нь юу гэж харж байгаа юм гэсэн ийм л товч хариулт авчихъя. Баярлалаа.

Н.Наранбаатар: Хэн хариулах хэдэн номер байна? 6 номер.

Н.Анхбаяр: Төсвийн байнгын хорооны дарга болон гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Үндэсний Аудитын газрын аудитын менежер Анхбаяр гэж хүн байна.

Энэ аудиттай холбоотой хууль маань бол 2022 онд батлагдсан. Батлагдсанаас хойш Засгийн газрын түвшинд бол батлах ёстой, дүрэм журам, хэм хэмжээнүүд бүгд батлагдаагүй шүү. Ийм байдалтай байж байгаа. Тэгэхээр хууль батлагдчихсан байгаад байхад энийг хэрэгжүүлэхгүй байгаа Засгийн газрыг бол өнөөдрийн түвшинд бол ажлаа хийхгүй байна гэж дүгнэсэн. Цаашдаа хуулийн үйлчлэлтэй холбоотой хэрэгжүүлснээрээ эерэг үр дүн гарах ийм нөхцөл байдал бол аудитын явцад анзаарагдсан.

Тэгэхээр зэрэг энэ бол одоогоор хэрэгжээд үйлчлээд энэ хууль маань байж байх юм бол энэ төсөвт захирагчдын санхүүгийн сахилга бат сайжрах болов уу гэсэн ийм байр суурьтай байна аа. Нэмэлт зүйл байхгүй.

Н.Наранбаатар: Тодруулах уу?

Тайлантай холбогдуулан гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүн сэдвээр хийсэн Нийцлийн аудитын тайланг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдээд мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

16.28 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА